



**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2015 оны 12 дугаар сарын 25

ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВ

ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ:

1. Ерөнхий мэдээлэл

2. ХЗҮХ-ийн төлөвлөгөөнд тусгагдсан болон төлөвлөгөөт бус ажил

2.1. Судалгаа, баримт бичгийн төсөл, санал зөвлөмж болон бусад бүтээгдэхүүн

2.1.1. Бодлогын ба бусад судалгаа

2.1.2. Баримт бичгийн төсөл, санал, зөвлөмж

2.1.3. Ном, гарын авлага, бусад бүтээгдэхүүн

2.1.4. Илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл

2.2. Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, лекц, сургалт, семинар

2.2.1. *Эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, лекц*

2.2.2. *Сургалт, семинар*

2.3 Номын сангийн үйл ажиллагаа

2.4. Бусад ажил

2.5 Дүгнэлт

**ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВИЙН
2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2015 оны 12 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий мэдээлэл

Энэхүү тайланд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн судалгааны төвийн 2015 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэлх хугацааны ажлын биелэлтийг тайлагнав.

Хууль зүйн судалгааны төв нь тайлант хугацаанд 2015 оны 1 дүгээр сарын 5-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдөр хүртэл 19 хүний бүрэлдэхүүнтэй ажилласан ба 2015 оны 3 дугаар сарын 7-ны өдрөөс бүтцийн өөрчлөлтөөр 9 хүний бүрэлдэхүүнтэй болсон. Үүнээс 12 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар дараах 8 ажилтны бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Үүнд:

1. Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан –220 хоног (бүтэн);
2. Бодлогын судлаач Ж. Бариаширсүрэн – 208 хоног;
3. Бодлогын судлаач Э.Уянга –164 хоног;
4. Бодлогын судлаач Б.Гончигсумлаа – 225 хоног (бүтэн);
5. Номын сангийн менежер, судлаач Х.Ариунсүрэн – 217 хоног;
6. Бодлогын судлаач Ж.Ариунцэцэг – 85 хоног;
7. Бодлогын судлаач Б.Ундрах 77 хоног;
8. Бодлогын судлаач Ц.Одгэрэл 54 хоног тус тус ажилласан.

Хууль зүйн судалгааны төвийн ажиллах журмын 5.1-т заасныг удирдлага болгож дараах бүтээгдэхүүнийг боловсруулан гаргасан байна. Үүнд:

- Бодлогын судалгаа;
- Лавлагаа;
- Судлаачийн зөвлөмж;
- Баримт бичгийн төсөл;
- Илтгэл, эрдэм шинжилгээний өгүүлэл, нийтлэл гэсэн судалгааны бүтээгдэхүүн багтаж байна.

Дээрх судалгааны бүтээгдэхүүнээс гадна хууль зүйн шинжлэх ухаан, хууль зүйн бодлого, хууль тогтоомж сурталчилан таниулах ажлын хүрээнд эрдэм шинжилгээний хурал, семинар, хэлэлцүүлэг, сургалт болон бусад арга хэмжээ зохион байгуулав.

Тайлант хугацаанд гүйцэтгэсэн судалгааны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг тайланд төрөлжүүлэн нэгтгэж тусгасан ба үүнээс ХЗҮХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажлыг төлөвлөгөөнд тусгагдсан дэс дугаарыг бичиж тодруулах **/bold-oor/** байдлаар ялгаж тэмдэглэсэн болно.

№	Зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Үнэл гээ	Биелэлт
ХУУЛЬ ЗҮЙН СУДАЛГААНЫ ТӨВ				
Судалгааны удирдлага, зохион байгуулалт				
1.	Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийг цэгцлэн сайжруулахад эрдэм шинжилгээний ажлыг чиглүүлэн чанар, үр нөлөөг дээшлүүлэх	2.1. Судалгааны арга зүй, хуулийн төслийн талаар цуврал семинар, уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах	100	Хууль зүйн судалгааны төвийн судлаачдад зориулсан судалгааны арга зүй, бодлогын судалгааны үе шат, бодлогын судалгааны тухай ойлголт, судлах зүйлийн хүрээг тодорхойлох арга, судалгааны ажил гүйцэтгэх процессын зураглал бүхий зааварчилгаа зэрэг судалгааны ажилд удирдлага болох арга зүйн гарын авлагыг боловсруулав. Боловсруулах явцад тус гарын авлагын дэд хэсэг тус бүрээр судалгааны семинарыг судлаачдын дунд зохион байгуулав. Тухайлбал, “Судалгааны ажлын үе шат, процесс зураглал”, “Бодлогын судалгаа, арга зүй”, “Судалгааны ажлын практик асуудал” гэсэн сэдвүүдээр арга зүйн семинар хийсэн.
БОДЛОГЫН БА БУСАД СУДАЛГАА, БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ БОЛОВСРУУЛАХ АЖИЛ				
2.	Хуулийн төсөл боловсруулах болон ЗГ-ын мөрийн хөтөлбөр, бусад бодлогын баримт бичигт заасан зорилтуудыг хэрэгжүүлэхэд судалгаагаар дэмжих чиг үүргийн дагуу	Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал /Бодлогын судалгаа/	100	Энэхүү судалгаагаар дотоодын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх талаарх онолын ерөнхий ойлголт болон гадаад улс орнуудын шүүхэд олон улсын эрх зүйн хэм хэмжээг хэрэглэж буй байдлыг харьцуулсны үндсэн дээр Монгол Улсын эрх зүйн орчинд тулгарч буй бэрхшээл, шийдвэрлэх арга замын талаар шинжлэн судалсан. Тоймловол: - Олон улсын гэрээг дотоодын шүүхэд хэрэглэх онол, практикийн зарим асуудлыг Нидерландын Вант Улс /НБУ/, Оросын Холбооны Улс /ОХУ/, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс /ХБНГУ/-ын жишээтэй харьцуулан судлав. - Монгол Улсын шүүхэд олон улсын гэрээг хэрхэн хэрэглэж байгаа талаар шүүгч, өмгөөлөгчдийн дунд санал асуулга явуулсан. Үүнд өмгөөлөгчдийн санал асуулгыг цахим хэлбэрээр буюу нийт 1411 өмгөөлөгчийн цахим хаяг руу илгээж 2014 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд цуглуулсан нийт 55

				оролцогчийн мэдээлэлд, шүүгчдийн санал асуулгыг Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн дэмжлэгтэйгээр нийслэлийн шүүхүүдийн тамгын газарт хүргүүлж 2014 оны 11 дүгээр сарын 19-ний өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийн хооронд цуглуулсан мэдээлэлд үндэслэн тус тус боловсруулалт хийж үр дүнг судалгаанд тусгалаа. Судалгааны үр дүнд, Монгол Улсын шүүхэд олон улсын гэрээг хэрэглэх эрх зүйн орчин, практикт үүссэн зарим маргаантай асуудлыг шийдвэрлэх арга замын талаар санал, зөвлөмж дэвшүүлсэн болно. Тус судалгааг 2014 - 2015 онд үргэлжлүүлэн гүйцэтгэсэн. Судалгааны товч тайланг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 3 дугаарт нийтлүүлж, судалгааны үр дүнг олон нийтэд мэдээлэв.
3.		Эрх зүйн бакалаврын зэрэг олгох сургалтын өнөөгийн нөхцөл байдлыг тодорхойлох нь /Бодлогын судалгаа/	100	Хууль зүйн мэргэжлийн боловсрол олгох тогтолцоог орчин үеийн олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэх, нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, эрх зүйн боловсрол болон мэргэжлийн эрэлт хоёрын зөрүүг ойртуулах зорилгоор шат дараалан судлах зорилт тавьсан ба эхний ээлжинд “Монгол Улс дахь эрх зүйн бакалаврын зэрэг олгох өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт судалгааг 2014 онд төлөвлөн хийж, 2015 онд үргэлжлүүлэн гүйцэтгэж дуусгалаа. Энэхүү судалгаагаар Монгол Улсад мэргэжлийн суурь мэдлэг олгодог эрх зүйн бакалаврын боловсролын талаар зохицуулж байгаа эрх зүйн зохицуулалтуудыг түүвэрлэн нэгтгэж, холбогдох хууль, эрх зүйн актын өөрчлөлт, зохицуулж байгаа харилцаа, энэ талаар эрдэмтэн судлаачдын судалсан байдал, судалгааны ажил, ном гарын авлага, эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, төсөл хөтөлбөр зэрэг эх сурвалжийн судалгаа хийж, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 11 их, дээд сургуулиас материаллаг нөхцөл байдал, сургалтын агуулга, багшлах боловсон хүчин, элсэгч, суралцагч, төгсөгчдийн талаар судалгаа авч тайланд нэгтгэв. Судалгааны явцад Хуульчдын холбоотой хамтран ажилласан ба судалгааны тайланг 2015 оны 2 дугаар сард

				Хууль зүйн яам болон Хуульчдын холбоонд хүлээлгэн өгсөн.
4.		3.3. “Мэргэшсэн хуульч” бэлтгэх тогтолцоо /харьцуулсан судалгаа/	100	Энэхүү судалгаагаар мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцооны түүхэн хөгжил, түүний дотор ХБНГУ, АНУ, БНСУ-ын тогтолцооны нийтлэг үндсэн асуудал, тухайлбал мэргэшсэн хуульч бэлтгэх сургалтад хамрагдах этгээдэд тавигдах шаардлага; сургалтын хөтөлбөр, сургалтын хугацаа; энэ төрлийн сургалт эрхлэх болон сургалтад хамрагдах этгээдэд улсаас үзүүлэх тэтгэлэг, тусламж; төгсөлтийн дараа олгох диплом, зэрэг цол; ажлын байрны хангамж, цалин зэрэг үндсэн асуудлуудыг харьцуулж, өнөөгийн нөхцөл байдал болон цаашдын чиг хандлагыг танадан судлах замаар тус тогтолцооны онцлог, давуу болон сул талыг тодорхойлох байдлаар судалгааг гүйцэтгэсэн. Судалгааны тайланг 7 дугаар сарын 06-ны өдөр ХЗЯ-нд хүргүүлэв.
5.		3.4. Гэр бүлийн гишүүдийн дундын эд хөрөнгийн өв залгамжлалын асуудал бодлогын судалгаа хийх	100	Энэ ажлын хүрээнд “Өв залгамжлал: Гэрээслэлээр өвлөх эрх” гэсэн сэдвээр нарийвчлан судлах нь зүйтэй гэж үзсэний дагуу, ХЗҮХ-ийн дүрэмд заасан зохицуулан холбох чиг үүргийн хүрээнд доктор С.Должин, судлаач М.Ванчигмаа нартай хамтран ажиллав. Тус судалгаагаар өв залгамжлал, түүний дотор гэрээслэлээр өвлөх эрхийн талаарх онолын ойлголт, гадаад улсуудын эрх зүйн зохицуулалтыг судалсны үндсэн дээр Монгол Улсын өнөөгийн эрх зүйн орчин, практик асуудлыг судалж, боловсронгуй болгох чиглэлээр санал, зөвлөмж боловсруулсан байна.
6.		3.7. Гадаадын иргэний эрх зүйн байдлын зарим асуудал /харьцуулсан судалгаа/	100	Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр хийх судалгааны төрөл, агуулгын асуудлаар Хууль зүйн яам, Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газар болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн холбогдох албан тушаалтан, мэргэжилтнүүд уулзаж санал солилцсоны дүнд дээрх хуулийн хэрэгжилтийн үр нөлөөний судалгаанаас илүүтэй холбогдох зарим асуудлыг хэрхэн шийдвэрлэдэг талаарх олон улсын зохицуулалт, гадаад орнуудын туршлагыг харьцуулан судлах хэрэгцээ, шаардлага байна хэмээн үзсэн болно. Иймд хуулийг

				боловсронгуй болгох ажлын хүрээнд судлах шаардлагатай гэж үзэж буй асуудлын хүрээ, тухайлж судлах гадаад орнуудыг тодорхойлох чиглэлээр албан бичгийн хүрээнд харилцсаны дүнд, ажлын удирдамж, төлөвлөгөө гаргасны дагуу Австрали, Сингапур, БНХАУ, ХБНГУ-ын эрх зүйн зохицуулалт, холбогдох туршлагыг харьцуулан дүгнэж, санал, зөвлөмж бүхий тайлан боловсруулав.
7.		3.8 Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдсон судалгаа	100	Шүүхийн шинжилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэрэгцээнд зориулсан энэхүү судалгааны хүрээнд Монгол Улсын болон Австрали, Эстони, Унгар, Солонгос улсын шүүхийн шинжилгээний үйл ажиллагаа эрхэлж буй байгууллагын бүтэц, зохион байгуулалт, санхүүжилт, чиг үүрэг, эрх зүйн зохицуулалт болон алба хаагчдын эрх зүйн байдлын талаар харьцуулан судалж, улмаар холбогдох хууль тогтоомжийн зохицуулалт болон шүүхийн шинжилгээний байгууллагуудын хөгжлийн өнөөгийн ба цаашдын чиг хандлагыг танадан дүгнэх байдлаар тайлан боловсруулж 2015 оны 7 дугаар сарын 6-ны өдөр ХЗЯ-нд хүргүүлэв.
8.		3.9. Хууль зүйн дипломын бус боловсролын 3 жилийн тогтолцоог нэвтрүүлэх ажилд бодлогын судалгаагаар дэмжлэг үзүүлэх	100	Тус хүрээлэн нь Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хууль зүйн мэргэжлийн болон иргэний боловсролын тогтолцоог боловсронгуй болгох, мэргэжлийн хуульч бэлтгэх тогтолцоог шинэ шатанд гаргах зорилтыг хангахад шинжлэх ухааны үндэслэлтэй бодлогын болон бусад судалгаагаар дэмжлэг үзүүлэх чиглэлээр ажиллаж байна. Энэ хүрээнд “Монгол Улс дахь эрх зүйн бакалаврын зэрэг олгох өнөөгийн нөхцөл байдал” сэдэвт судалгааг 2014-2015 онд үргэлжлүүлэн гүйцэтгэж дуусгасан бол “Мэргэшсэн хуульч бэлтгэх тогтолцоо: Харьцуулсан судалгаа” –г 2015 оны эхний хагас жилд гүйцэтгэсэн. Эдгээр судалгааны үр дүнд тулгуурлан “Хууль зүйн дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлэх ажилд бодлогын судалгаагаар дэмжлэг үзүүлэх нь “ сэдэвт судалгааг их, дээд сургуулиудтай хамтран ажиллах

				хэрэгцээ, шаардлагыг харгалзан 2015 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлүүлсэн болно. Хууль зүйн яамны холбогдох мэргэжилтэнтэй уулзаж “Эрүүл мэндийн шинжлэх ухаан дахь төгсөлтийн дараах үндсэн мэргэшлээр (резидент) мэргэшүүлэх сургалтын эрх зүйн зохицуулалт”-ыг энэ судалгааны хүрээнд харьцуулан судалж холбогдох материалыг нэгтгэж өгсөн. Хууль зүйн яамны мэргэжилтэнтэй холбогдон энэ чиглэлийн судлаач, эрдэмтэдтэй фокус ярилцлага хийсэн. 2015 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр Хууль зүйн яам, Хуульчдын холбоотой хамтран “Хууль зүйн мэргэшүүлэх сургалтыг Монгол Улсын хууль зүйн их, дээд сургуульд нэвтрүүлэх нь” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулав. Хэлэлцүүлэгт оролцогсдын дээрх сэдвийн хүрээнд илэрхийлсэн санал, зөвлөмжийг тусгасан хэлэлцүүлгийн тайлан боловсруулсан. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүн болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2012 оноос хойш хийсэн судалгааны ажилд тулгуурлан Монгол Улсын хууль зүйн боловсрол олгох өнөөгийн тогтолцоо, чиг хандлага, эрх зүйн зохицуулалт, онцлог, уялдаа холбоо, харилцан хамаарлыг судлан дипломын бус боловсролын тогтолцоог нэвтрүүлэх арга замын тухайд санал, зөвлөмж боловсруулав.
9.		3.10 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, хууль, эрх зүйн зохицуулалт /Лавлагаа/	100	ХЗЯ-ны захиалгын дагуу Узбекистан улсын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын эрх зүйн зохицуулалттай харьцуулан судалсан лавлагааны тайланг ХЗЯ-нд хүргүүлсэн.
10		3.11 Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны үе шат /Харьцуулсан судалгаа/	100	Тус судалгааг ХЗЯ-ны захиалгаар 3 дугаар сарын 15-ны өдрөөс 4 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд гүйцэтгэв. Энэхүү судалгааны хүрээнд ХБНГУ болон БНСУ-ын эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны тухай судалж, харьцуулан дүгнэлт хийх байдлаар судалгааг гүйцэтгэж санал, дүгнэлт бүхий тайланг 4 дүгээр сарын 15-ны өдөр ХЗЯ-нд албан тоотоор хүргүүлэв.

11		3.12.Төрийн бус байгууллагын санхүүжилт, татварын эрх зүйн зохицуулалт / бодлогын судалгаа/	100	Энэ ажлын хүрээнд Монгол, БНХАУ, Унгар улсын төрийн бус байгууллагын татварын эрх зүйн зохицуулалтыг харьцуулан судлав. ХЗҮХ-ээс энэ чиглэлээр хэд хэдэн судалгаа гүйцэтгэж байсныг харгалзан өмнөх судалгаанд хамрагдаагүй улсуудыг сонгон судалсан бөгөөд төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын сайн туршлага бүхий бүс нутагт зүй ёсоор тооцогддог Төв болон Зүүн Европын орнуудаас Унгар улсыг, төрийн бус байгууллагын эрх зүйн зохицуулалтын чиглэлээр шинэчлэл хийгдэж буй БНХАУ-ыг тус тус харьцуулан судалсан. Судалгаанд дээрх орнууд төрийн бус байгууллагыг эрх зүйн хувьд хэрхэн авч үзэж байгааг тодруулсны үндсэн дээр татварын дэглэмийг тодорхойлох зарчмыг баримталсан болно.
12		3.13. Рецидив гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудал судлаачийн зөвлөмж боловсруулах	100	Энэхүү ажлын хүрээнд рецидив гэмт хэргийн ерөнхий ойлголт, энэ төрлийн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг тодорхойлж, өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр урьдчилан сэргийлэх арга замын талаар зөвлөмжилсөн болно.
13		Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт, хүндрэл бэрхшээл /захиалгат судалгаа/	80	Хууль зүйн яамны захиалгат энэхүү ажлын хүрээнд эх сурвалжийн болон социологийн судалгаа хийх талаар ХЗЯ-ны Эрх зүйн шинэчлэлийн бодлогын газрын дарга Т.Бат-Өлзийтэй зөвлөлдсөн. Тус хуулийн хэрэгжилтийн талаар өмнө хийгдсэн судалгаа, судлаачдын бүтээлд дэвшүүлсэн асуудал, шийдвэрлэх саналыг түүвэрлэж эх сурвалжийн судалгааг дуусгасан. Энэ шатны ажлын үр дүнд тулгуурлан шүүгч, өмгөөлөгчдийн дунд явуулах 2 төрлийн асуулга боловсруулж Иргэний хэргийн анхан шатны нийт 300 орчим шүүгч болон 800 орчим өмгөөлөгчдийн цахим хаягаар илгээсэн бөгөөд үр дүнг хүлээж байна.
		БАРИМТ БИЧГИЙН ТӨСӨЛ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ		
1		3.5 Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдлын талаарх	100	Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгийн хуралдаанаас гаргасан шийдвэрийн дагуу төрийн байгууллагуудаас ирүүлэх НҮБ-ын зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан нэгтгэх, улмаар илтгэл бичих ажилд

		үндэсний хоёрдугаар илтгэл/UPR/ бэлтгэх		ХЗҮХ оролцох үүрэг хүлээсний дагуу Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, Бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн нар холбогдох байгууллагуудаас ирүүлсэн мэдээ тайланг нэгтгэн хэрэгжилтийн тайлан боловсруулж, ажлын хэсэгт хүлээлгэж өгөв. Хэрэгжилтийн тайланд үндэслэн үндэсний илтгэл боловсруулах ажилд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, Бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн, Т.Саруул нар оролцов. Илтгэлийн эцсийн хувилбарт 15 зүйл бүхий санал бэлтгэж ажлын хэсэгт хүргүүлсэн. Төрийн болон төрийн бус байгууллагуудаас зохион байгуулсан холбогдох хэлэлцүүлгүүдэд тухай бүр оролцож, мэдээлэл хийв. Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын талаарх Үндэсний хоёрдугаар илтгэлийг НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлийн Ээлжит нэгдсэн хэлэлцүүлгийн ажлын хэсгийн 22 дугаар чуулганаар энэ оны 5 дугаар сарын 5-наас 8-ны өдрүүдэд Женев хотноо хэлэлцсэн байна.
2		3.6 Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн Академийн хооронд байгуулах “Хамтын ажиллагааны санамж бичиг”- ийн төсөл	100	Хууль зүйн үндэсний хүрээлэн болон Бүгд Найрамдах Турк Улсын Хууль зүйн Академийн хооронд байгуулах “Хамтын ажиллагааны санамж бичиг”-ийн төсөл боловсруулж, төслийг монгол, англи хэл дээр ХЗЯ-нд албан тоотоор болон цахим хэлбэрээр хүргүүлэв.
3		3.13 Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл- /Ажлын хэсгийн хүрээнд санал, зөвлөмж боловсруулах/	100	Олон улсын гэрээний тухай хуулийг боловсронгуй болгох чиглэлээр ГХЯ-наас байгуулсан Ажлын хэсэгт Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан ажилласан бөгөөд тус хуулийг шинэчлэн найруулах хүрээнд санал, зөвлөмж боловсруулж, үндэслэлийн хамт хүргүүлэв. Олон улсын эрх зүйг хэрэглэхтэй холбоотой онол, практикийн асуудлаар ГХЯ-ны Гэрээ, эрх зүйн газартай харилцаж, хамтран ажиллав. 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Төрийн ордонд болсон Олон улсын гэрээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн

				хэлэлцүүлэгт Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцов.
		Төлөвлөгөөт бус цаг үеийн шинжтэй лавлагаа, холбогдох баримт бичгийн төсөлд санал, зөвлөмж бэлтгэх		
4		Монгол Улсын Их хурлын тухай хууль, Монгол Улсын Их хурлын чуулганы дэгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл бэлтгэх		Монгол Улсын Их хурлын тухай хууль, Монгол Улсын Их хурлын чуулганы дэгийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, гадаад орнуудын туршлагыг харьцуулан судлах замаар Монгол Улс дахь өнөөгийн нөхцөл байдалд тохиромжтой байж болох хувилбарын талаар судлаачийн санал, зөвлөмж боловсруулсны үндсэн дээр уг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл бэлтгэв.
5		ХЗЯ-аас ирүүлсэн албан бичгийн хүрээнд	100	Хууль зүйн сайдын эрхлэх асуудлын хүрээний гадаад харилцааг хөгжүүлэх хөтөлбөрийг 2014-2018 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 2015 онд хэрэгжүүлэх гадаад харилцааны төлөвлөгөөний санал боловсруулж ХЗЯ-нд хүргүүлэв.
6				Хууль зүйн яамнаас АНУ-ын Төрийн департаментийн Олон улсын мансууруулах бодис, хууль сахиулах үйл ажиллагааны товчоотой хамтран хэрэгжүүлэх төслийн хүрээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнд ирүүлсэн албан бичигт санал бэлтгэж 2015 оны 3 дугаар сарын 5-ны өдөр хүргүүлэв.
7				Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах зорилтот арга хэмжээнд тусгуулах санал хүргүүлэв.
8				Монгол Улсын Хууль зүйн яам, БНХАУ-ын Хууль зүйн яам хооронд байгуулсан харилцаа, хамтын ажиллагааны тухай санамж бичгийг хэрэгжүүлэх зорилгоор Талууд 2015-2017 онд хамтран ажиллах хөтөлбөрийн төсөлд санал боловсруулж хүргүүлэв.
9				Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх асуудлын хүрээнд төрийн байгууллагуудаас санал авах тухай албан бичигт хариу тоот боловсруулж, хавсралтаар холбогдох судалгааг хүргүүлэв.

10		Бусад байгууллагаас ирүүлсэн албан бичгийн хүрээнд		2015 оны 1 дүгээр сард ГХЯ-аас Монгол Улс болон АНУ-ын хооронд байгуулсан “Ил тод байдлыг хангах тухай хэлэлцээр”-ийн биелэлтийг хангуулахаар эрх зүйн баримт бичгийг англи хэл рүү хөрвүүлэх тусгай нэгжийг байгуулах ажилд санал авах тухай албан тоот ирсний дагуу холбогдох баримт бичгийг судалж санал хүргүүлэв.
11			100	2016 оноос эхлэн хэрэгжүүлэх Шинжлэх ухаан, технологийн төслийн саналд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс хэрэгжүүлэх боломжтой төслийн санал боловсруулж хүргүүлэв.
12				Хууль зүйн яамны 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 3/3269 дугаар бүхий албан бичгийн дагуу, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан хууль тогтоомжийн төсөл боловсруулахтай холбогдох аргачлал боловсруулах ажлын хэрэгцээнд олон улсын эрх зүйн холбогдох зохицуулалт, бусад улсын адил төстэй хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа хийхэд баримтлах арга зүйн талаар Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан мэдээлэл, санал хүргүүлэв.
13		Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлын хүрээнд		Хууль зүйн яамны 2015 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн 1/3914 дугаартай албан бичгийн дагуу, Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг үндэслэн Засгийн газрын тогтоолоор батлах “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”, “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”, “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт, шинжилгээ хийх аргачлал”, “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” –ын төслүүдтэй танилцаж, дээрх 6 аргачлалын төсөл тус бүр дээр санал боловсруулан ХЗЯ-нд хүргүүлэв.
Ном, гарын авлага, бусад бүтээгдэхүүн				
1	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл (2015 оны №1)	100	Сэтгүүлийн дугаар бүрийг цаг тухайд нь эрхлэн гаргасан ба аж ахуйн нэгж,

				байгууллагуудаар түгээх ажил хийгдэв.
2	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл (2015 оны 2)	100	Сэтгүүлийн дугаарыг цаг тухайд нь эрхлэн гаргасан ба аж ахуйн нэгж, байгууллагуудаар түгээх ажил хийгдэв.
3	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл (2015 оны №3)	100	Сэтгүүлийн дугаарыг цаг тухайд нь эрхлэн гаргасан ба аж ахуйн нэгж, байгууллагуудаар түгээх ажил хийгдэв.
4	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл	“Хууль дээдлэх ёс” сэтгүүл (2015 оны №4)	90	Сэтгүүлийн дугаарт хэвлүүлэхээр ирүүлсэн нийтлэлүүдийг хянан эмхэтгэж хэвлэлтэд шилжүүлэв.
5	“LAW REVIEW”	“LAW REVIEW” англи дугаар (2015 оны №5)	90	“LAW REVIEW” англи хэл дээрх дугаарт хэвлүүлэхээр ирүүлсэн нийтлэлүүдийг хянан эмхэтгэж хэвлэлтэд шилжүүлэв.
6	Сургалтын гарын авлага	“Хууль зүйн англи хэлний орчуулгын гарын авлага: эрх зүйн баримт бичиг, худалдааны гэрээ”	100	Хууль зүйн англи хэлний сургалтад зориулан доктор И.Идэш, Бодлогын судлаач Б.Ундрах, Г.Түвшинжаргал нар “Хууль зүйн англи хэлний орчуулгын гарын авлага: эрх зүйн баримт бичиг, худалдааны гэрээ” сэдвээр гарын авлага боловсруулж гаргасан. Уг номын зорилго нь хууль зүйн англи хэл дээр орчуулга хийх, Монголын хууль, эрх зүйн актын хэм хэмжээг орчуулах, ялангуяа компани үүсгэн байгуулах баримт бичиг, гэрээ хэлцлийг боловсруулахад дадал олгох юм. ХЗҮХ-ийн хууль зүйн англи хэлний сургалтад ашиглагдаж байна.
7.	Судалгааны ажлын дотоод хэрэгцээнд зориулсан гарын авлага	Судлаачийн гарын авлага	100	Хууль зүйн судалгааны төвийн судлаачдад зориулан судалгааны ажлын онцлог, судалгааны тайлангийн агуулга, хэлбэр, бүтэц, судалгааны ажил гүйцэтгэх процессын зураглал бүхий зааварчилгаа, удирдлага болох дүрэм журмыг эмхэтгэсэн гарын авлага боловсруулав.
8.	Монгол Улсын хууль тогтоомжийг гадаад хэл дээр орчуулж хэвлүүлэх	Монгол Улсын хууль тогтоомжийн эмхэтгэл-IV боть /хятад хэл дээр/	100	Байгаль орчныг хамгаалах тухай, Ашигт малтмалын тухай, Хөрөнгө оруулалтын тухай зэрэг байгаль орчин, уул уурхай, хөрөнгө оруулалт, газрын харилцааг зохицуулсан, Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа 30 гаруй хууль болон холбогдох тогтоолыг хятад хэл рүү орчуулж эмхэтгэсэн “Монгол Улсын хууль тогтоомжийн эмхэтгэл”- IV боть номыг Хууль зүйн үндэсний хүрээлэн “Ард” өмгөөлөгчийн товчоо, Өмгөөллийн “Яшинсүлд” ХХН-тэй хамтран хэвлүүлэв.

9.	Эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл хэвлүүлэхэд оролцох	“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэл	100	2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн, Үндэсний тагнуулын академи, МУИС-ийн Хууль зүйн сургууль, МУИС-ийн Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль хамтран зохион байгуулсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхэтгэлд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалангийн “Хүнсний аюулгүй байдлын олон улсын эрх зүйн зохицуулалт: Хүний эрхэд суурилсан хандлага” сэдэвт илтгэл хэвлэгдсэн.
10.		“Их засгийн эхийг эрэн сурвалжлах нь” - олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл	100	2015 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэц, ХЗҮХ, Их Засаг олон улсын их сургууль хамтран зохион байгуулсан “Их засгийн эхийг эрэн сурвалжлах нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэлд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалангийн БНХАУ дахь “Их Засаг”-ийн судалгаа сэдэвт илтгэл хэвлэгдсэн.
		“Прокурорын байгууллагын түүхэн замнал, үйл ажиллагаа, цаашдын хөгжлийн чиг хандлага” сэдэвт онол практикийн хурлын илтгэлийн эмхэтгэл	100	Прокурорын байгууллагын 85 жилийн ойд зориулсан онол практикийн хуралд Бодлогын судлаач Б.Одонгэрэлийн “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд эрх зүйн тогтолцооны онцлог нөлөөлөх нь” сэдэвт илтгэл хэвлэгдсэн.
11		“Посткоммунист орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба Монголын эрх зүйн тогтолцооны төлөвшил, онцлог” олон улсын бага хурлын илтгэлийн эмхэтгэл	100	Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, МУИС-ийн Харьцуулсан эрх зүй, олон улсын эрх зүйн судалгааны төв, олон улсын эрх зүйн тэнхим хамтарч зохион байгуулсан тус хурлын илтгэлийн эмхэтгэлд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалангийн “Орчин үеийн Хятадын эрх зүйн онцлог” сэдэвт илтгэл хэвлэгдсэн.
ИЛТГЭЛ, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ, НИЙТЛЭЛ				
1		Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх	100	Шүүхийн ерөнхий зөвлөлөөс эрхлэн гаргадаг “Шүүх эрх мэдэл” сэтгүүлд “Гэмт хэрэгтнийг нийгэмшүүлэх асуудал”

		асуудал		сэдвээр бодлогын судлаач Б.Одонгэрэл нийтлэл бичсэн.
2	Судалгааны бүтээгдэхүүний үр дүнг олон нийтэд мэдээлэх, сурталчлах ажлын хүрээнд	Төрөөс улсын тусгай хэрэгцээг үндэслэн иргэний эзэмшил, өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор солих болон эргүүлэн авах, түүний эрх зүйн зохицуулалт	100	Монголын Эмнести Интернэшнл байгууллагаас зохион байгуулсан “Газартай холбоотой хүний эрхийн асуудлууд” сэдэвт онол, практикийн бага хуралд “Төрөөс улсын тусгай хэрэгцээг үндэслэн иргэний эзэмшил, өмчлөлийн газрыг нөхөх олговортойгоор солих болон эргүүлэн авах, түүний эрх зүйн зохицуулалт” сэдвээр бодлогын судлаач Б.Гончигсумлаа илтгэл хүргүүлэв.
3		Монгол Улс дахь албадан ажил хийлгэх ялын зохицуулалтыг сайжруулах нь	100	Албадан ажил хийлгэх ялын түүхэн эх сурвалж, практикт тулгарч байгаа бэрхшээлийг судалж илтгэл бэлтгэн ХБНГУ-ын Макс Планкийн Институт дээр зохион байгуулагдсан эрдэм шинжилгээний семинарт хэлэлцүүлэв.
4		Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал		“Монгол Улсын олон улсын гэрээг шүүхэд хэрэглэх асуудал” сэдэвт бодлогын судалгааны товч тайланг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлд нийтлүүлэв.
5		Олон улсын байгууллагын эрх зүйн байдал, хүлээх хариуцлага /Олон улсын ба үндэсний эрх зүйн жишээн дээр/		Бодлогын судлаач Э.Туулайхүү “Олон улсын байгууллагын эрх зүйн байдал, хүлээх хариуцлага - Олон улсын ба үндэсний эрх зүйн жишээн дээр” сэдэвт эрдэм шинжилгээний өгүүллийг “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2015 оны №02 (52) дугаарт нийтлүүлэв.
6		<i>БНХАУ дахь “Их Засаг” судлалын төлөв</i>		Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан 2015 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэц, ХЗҮХ, Их Засаг олон улсын их сургууль хамтран зохион байгуулсан “Их засгийн эхийг эрэн сурвалжлах нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хуралд БНХАУ дахь “Их Засаг” судлалын төлөв сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.
7		Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог		ХБНГУ-ын “Ханнс-Зайделийн сан”, “Суурийн Жанцан сан” хамтран магистр ба түүнээс дээш зэрэгтэй судлаачид, практик ажилтнуудын дунд зарласан “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа-онол ба практик” эрдэм шинжилгээний уралдаанд бодлогын

				судлаач Б.Одонгэрэл “Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны эрх зүйн тогтолцооны онцлог” сэдвээр илтгэл хэлэлцүүлж тусгай байр эзэлсэн.
8		Хүнсний аюулгүй байдлын олон улсын эрх зүйн зохицуулалт: Хүний эрхэд суурилсан хандлага		2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн, Үндэсний тагнуулын академи, МУИС-ийн Хууль зүйн сургууль, МУИС-ийн Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль хамтран зохион байгуулсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан “Хүнсний аюулгүй байдлын олон улсын эрх зүйн зохицуулалт: Хүний эрхэд суурилсан хандлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.
9		Монгол Улс дахь хууль зүйн дээд боловсролын эрх зүйн зохицуулалт	100	Бодлогын судлаач Э.Уянга “Монгол Улс дахь хууль зүйн дээд боловсролын эрх зүйн зохицуулалт” сэдвээр эрдэм шинжилгээний өгүүлэл бэлтгэж “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2015 оны №3 дугаарт хэвлүүлэв.
10		“Хууль зүйн үндэсний хүрээлэн олон улсын эрх зүйн чиглэлээр судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил өргөн өрнүүлдэг” нийтлэл		Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан “Хууль зүйн үндэсний хүрээлэн олон улсын эрх зүйн чиглэлээр судалгаа, сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажил өргөн өрнүүлдэг” сэдвээр нийтлэл бэлтгэж www.legalinfo.mn цахим хуудас дахь “Эрх зүйн хөгжил” буланд байршуулав.
11		Хээл хахуулийн гэмт хэрэгт хүлээлгэх ялгамжтай ялын бодлого		ХБНГУ-ын <i>Фрайбург</i> дахь Макс-Планкийн институтын Гадаадын болон олон улсын эрүүгийн эрх зүйн институтээс зохион байгуулсан “Эрүүгийн ял шийтгэл, дэлхий нийтийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний семинарт Бодлогын судлаач Б.Ундрах “Хээл хахуулийн гэмт хэрэгт хүлээлгэх ялгамжтай ялын бодлого” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв. Мөн тус илтгэлийг англи хэл дээр “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн №5 дугаарт нийтлүүлэв.
12		“Их Засаг”-ийн судалгааны тойм	100	Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан БНХАУ-ын Өвөрмонголын их сургуулийн Хууль зүйн сургуулийн Үндэсний эрх зүй судлалын тэнхимийн эрхлэгч доктор,

				профессор Д.Наранцогттой хамтран “Их Засаг”-ийн судалгааны тойм сэдвээр “Хууль дээдлэх ёс” сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэв.
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ, ХЭЛЭЛЦҮҮЛЭГ, УУЛЗАЛТ, СУРГАЛТ, СЕМИНАР, БУСАД ТОМООХОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АРГА ХЭМЖЭЭ				
1	Эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулах, оролцох	“Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал	100	Хууль зүйн үндэсний хүрээлэн 2015 оны 5 дугаар сарын 27-ны өдөр Үндэсний тагнуулын академи, МУИС-ийн Хууль зүйн сургууль, МУИС-ийн Олон Улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуультай хамтран “Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
2		“БНХАУ дахь “Их Засаг” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал		Хууль зүйн үндэсний хүрээлэн 2015 оны 5 дугаар сарын 8-ны өдөр Үндсэн хуулийн цэц, Их Засаг олон улсын их сургуультай хамтран “Их засгийн эхийг эрэн сурвалжлах нь” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулав.
3		“Эрүүгийн ял шийтгэл, дэлхийн нийтийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний семинар		Хууль зүйн үндэсний хүрээлэн болон ХБНГУ-ын Макс Планкийн Гадаад болон олон улсын эрүүгийн эрх зүйн институтын хооронд байгуулсан Шинжлэх ухааны хамтын ажиллагааны суурь гэрээний хүрээнд ХБНГУ-ын Фрайбург хотод 2015 оны 10 дугаар сарын 18-24-ний өдрүүдэд Герман-Монголын хамтарсан “Эрүүгийн ял шийтгэл, дэлхийн нийтийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний семинар зохион байгуулагдсан. Тус семинарт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал, хууль зүйн ухааны доктор Э.Батбаяр “Монгол Улсын эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлт” сэдвээр, Бодлогын судлаач Б.Ундрах “Хээл хахуулийн гэмт хэрэгт хүлээлгэх ялгамжтай ялын бодлого” сэдвээр, бодлогын судлаач Б.Одонгэрэл “Монгол Улс дахь албадан ажил хийлгэх ялын зохицуулалтыг сайжруулах нь” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.
4		“Эрх зүйт төр-эрхэм зорилго” олон улсын онол-практикийн бага хурал		Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хороо, Хууль зүйн яам, ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сан хамтран 2015 оны 05 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсан “Эрх зүйт төр-эрхэм зорилго” олон улсын онол-практикийн бага хуралд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач С.Бүжинлхам, Б.Гончигсумлаа нар оролцов.
5		“Үндсэн хууль тайлбарлах онол,		2015 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын

		арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал	100	хорооноос зохион байгуулсан “Үндсэн хууль тайлбарлах онол, арга зүй” сэдэвт эрдэм шинжилгээний бага хуралд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцов.
6		“Байнгын ажиллагаатай парламент 25 жил” сэдэвт эрдэм шинжилгээний хурал		2015 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан тус эрдэм шинжилгээний хуралд Хууль зүйн судалгааны төвийн Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач Ж.Ариунцэцэг, Э.Уянга нар оролцов.
7		“Төрийн тусгай чиг үүрэг бүхий байгууллагуудын менежментэд тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга зам” сэдэвт онол, практикийн бага хурал		2015 оны 12 дугаар сарын 5-ны өдөр зохион байгуулагдсан тус хуралд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцов.
8	Лекц, хэлэлцүүлэг, уулзалт	“Монгол Улс дахь Үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хууль дахь парламентын эрх мэдэл” хүндэтгэлийн лекц		2015 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр Төрийн ордны Их танхимд зохион байгуулагдсан Б.Лүндээжанцангийн “Монгол Улс дахь Үндсэн хуульт ёсны төлөвшил, Үндсэн хууль дахь парламентын эрх мэдэл” сэдвээр уншсан хүндэтгэлийн лекцэд Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцов.

9		Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс зохион байгуулдаг “Эрх зүй ба хөгжил” цуврал лекц хэлэлцүүлэг	100	ХЗҮХ-ээс уламжлал болгон зохион байгуулдаг “Эрх зүй ба хөгжил” цуврал лекц хэлэлцүүлгийн хүрээнд 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэгийн “Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал: уламжлалт морин уралдаан ба хүүхдийн эрхийн асуудал”, 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдөр хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайханы “Засгийн газрыг эмхлэн байгуулах ажиллагааг боловсронгуй болгох замаар парламентын засаглалыг бэхжүүлэх нь”, 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр хууль зүйн ухааны доктор, дэд профессор Ш.Цогтоогийн “Үндсэн хуулийн долоон нэмэлт өөрчлөлт харьцуулсан судалгаа хууль зүйн шинжилгээ”, 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газрын ахлах зөвлөх, хууль зүйн магистр П.Амаржаргалын “Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал: Парламентын бүрэн эрх” сэдэвт лекц хэлэлцүүлгүүдэд нийт бүрэлдэхүүн оролцов.
10		“Хэрэглэгчийн эрхийн төлөв байдал ба хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэг		Бодлогын судлаач Э.Ганчулуун 2015 оны 3 дугаар сарын 10-ны өдөр Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газраас зохион байгуулсан “Хэрэглэгчийн эрхийн төлөв байдал ба хэрэглэгчийн эрхийг хамгаалах эрх зүйн орчны шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлэгт оролцов.
11		“Хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудал” сэдэвт хэлэлцүүлэг		МХХ-ны Олон улсын эрх зүйн хорооноос 2015 оны 3 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан “Хурдан морь унаач хүүхдийн эрхийн асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт Бодлогын судлаач Б.Энх-Амгалан оролцов.
12		“Эрх зүйн маргааныг эвлэрүүлэн зуучлах журмаар шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт гарын авлагыг танилцуулах нээлтийн ажиллагаа		ХЗҮХ, Жайка хамтран зохион байгуулсан арга хэмжээнд Бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн оролцов.
13		Цахим		

		засаглалаар дамжуулан хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн нээлт, хэлэлцүүлэг	100	2015 оны 12 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан “Цахим засаглалаар дамжуулан хууль боловсруулах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх нь” төслийн нээлт, хэлэлцүүлэгт бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцов.
14		“Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэг		Монгол Улсын Их Хурлын Хууль Зүйн Байнгын Хорооноос 2015 оны 5 сарын 14-ний өдөр Төрийн ордны “Б” танхимд зохион байгуулсан “Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай” хуулийн төслийн хэлэлцүүлэгт Бодлогын судлаач Б.Одонгэрэл оролцов.
15		Захиргааны ерөнхий хууль”-ийн танилцуулга, мэдээллийн уулзалт		ХЗҮХ-ээс 2015 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Хуульчдын танхимд зохион байгуулсан “Захиргааны ерөнхий хууль”-ийн танилцуулга, мэдээллийн уулзалтад нийт судлаачид оролцов.
16		“Эрүү шүүлт болон гэмт хэргийн хохирогчийн эрхийн өнөөгийн төлөв байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэг		2015 оны 6 сард Хүний эрхийн Үндэсний Комиссоос Эрүү шүүлтийн хохирогчдын эрхийг дэмжих олон улсын өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Эрүү шүүлт болон гэмт хэргийн хохирогчийн эрхийн өнөөгийн төлөв байдал, цаашид анхаарах асуудал” сэдэвт хэлэлцүүлэгт ХЗҮХ-ийн зүгээс бодлогын судлаач Б.Одонгэрэл “Хохирогчийн эрхийн асуудал” сэдвээр мэдээлэл хийв.
17		“Хулгайлсан болон хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн тухай 1995 оны ЮНИДРУА-ийн конвенц”	100	ЮНЕСКО-ийн Монголын Үндэсний комисс, Гадаад хэргийн яам, Боловсрол, соёл шинжлэх ухааны яам, Хууль зүйн яам хамтран 2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан “Хулгайлсан болон хууль бусаар экспортолсон соёлын эд зүйлсийн тухай 1995 оны ЮНИДРУА-ийн конвенц”-д Монгол Улс нэгдэх боломжийг судлах дугуй ширээний уулзалт хэлэлцүүлэгт Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, Бодлогын судлаач Э.Туулайхүү нар оролцов.
18		“Боловсролын эдийн засаг ба үр өгөөж” хэлэлцүүлэг		БСШУЯ-аас Дэлхийн банктай хамтран зохион байгуулсан Боловсролын эдийн засаг ба үр өгөөж” лекц, хэлэлцүүлэгт Бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн, Э.Уянга, Ж.Ариунцэцэг нар оролцов.

19	Сургалт	“Бизнесийн маргаан шийдвэрлэх тогтолцоо, Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй” -хууль зүйн англи хэлний сургалт	100	ХЗҮХ-ээс зохион байгуулсан Хууль зүйн англи хэлний сургалтад Бодлогын судлаач Э.Туулайхүү, Б.Ундрах нар хичээл заав.
20		“Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилт: Хүний эрх” сэдэвт сургалт		Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулсан эрх зүйн албан бус сургалтад Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан “Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилт: Хүний эрх” сэдвээр сургалт хийв.
21		“Судалгааны ажлыг ёс зүйн болон эрх зүйн шаардлагад нийцүүлэх нь” сэдэвт сургалт		ХБНГУ-ын Ханнс Зайделын сангаас зохион байгуулсан “Судалгааны ажлыг ёс зүйн болон эрх зүйн шаардлагад нийцүүлэх нь” сэдвээр ХБНГУ-ын доктор Армин фон Вишпфеннигийн сургалтад Хууль зүйн судалгааны төвийн нийт судлаачид оролцов.
22		“Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоо” сэдэвт олон улсын ахлах ажилтны хүрээний семинар		Япон улсын Токио хотноо зохион байгуулагдсан “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ба эрүүгийн байцаан шийтгэх тогтолцоо” сэдэвт олон улсын ахлах ажилтны хүрээний семинарт Бодлогын судлаач Б.Одонгэрэл 2015 оны 1 дүгээр сарын 12-ны өдрөөс 2 дугаар сарын 14 –ний өдөр хүртэл оролцож мэргэжил дээшлүүлэв.
23		“Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын сургалт”		Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг /GIZ/-ээс зохион байгуулсан “Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлалын сургалтад бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн, Э.Туулайхүү, Б.Гончигсумлаа, Ж.Ариунцэцэг, Б.Ундрах нар 2015 оны 3 дугаар сарын 23- 27, 2015 оны 10 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд хамрагдаж, гэрчилгээ авав.
24		“Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын		Хууль зүйн үндэсний хүрээлэн 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд НҮБ-ын Хүүхдийн сан, Хувь хүний хөгжлийн институттай хамтран “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын

		стандарт”		стандарт” сэдвээр үндэсний сургагч багш бэлтгэх 4 өдрийн /32 цагийн/ сургалт зохион байгуулсан ба тус сургалтад Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач Ж.Бариаширсүрэн нар хамрагдаж гэрчилгээ авав.
25		“Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт дотоод сургалт		“Архив, албан хэрэг хөтлөлт” сэдэвт дотоод сургалтад нийт бүрэлдэхүүн хамрагдав.
26	Зохион байгуулсан томоохон арга хэмжээ	“Хуульчдын өдөр”		2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр ХЗЯ, ХЗҮХ, МХХ хамтран зохион байгуулсан “Хуульчдын өдөр”-ийн арга хэмжээнд нийт судлаачид оролцов.
27		Хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээ		Хууль зүйн яамнаас 2015 оны 9 дүгээр сарын 7-ны өдрөөс 14-ний өдрүүдэд зохион байгуулсан тус өдөрлөгт Бодлогын судлаач Б.Гончигсумлаа, Ж.Ариунцэцэг нар оролцсон ба тус арга хэмжээнд Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс иргэдэд зориулж эрх зүйн мэдээллийн нугалбар хуудас, "Хууль зүйн мэдээлэл" эмхэтгэл, "Хууль зүйн мэдээ" сонин, "Хууль дээдлэх ёс" сэтгүүл болон бусад гарын авлагуудыг үнэ төлбөргүй тарааж, шинээр батлагдсан хууль тогтоомжийн талаар мэдээлэл өгч ажиллав.
28		Хуульчийн мэргэшлийн шалгалт-2015	100	Хууль зүйн судалгааны төвийн нийт судлаачид Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах ажлын хүрээнд 9 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд шалгалт зохион байгуулах байранд, 9 дүгээр сарын 21, 22, 23-ны өдрүүдэд УЕПГ-ын дэргэдэх “Прокурорын сургалт” судалгааны төв”-д тус тус ажиллав. Мөн 9 дүгээр сарын 26, 27-ны өдрүүдэд өргөдөл шийдвэрлэх, 9 дүгээр сарын 30, 10 дугаар сарын 1, 2, 9-ний өдрүүдэд шалгалтын материал архивлах ажилд тус тус оролцов.
Номын сангийн үйл ажиллагаа				
1.	Судалгааны дэд бүтцийг хөгжүүлэх, номын санг сайжруулах	5.1.Гадаад ба дотоодын орчин үеийн ном зохиолоор номын фонд сайжруулах 5.2. Номын санг цахимжуулах	100	2015 оны 12 дугаар сарын 15-ний өдрийн байдлаар хүрээлэнгийн номын сангийн фонд монгол хэл дээр 12000, гадаад хэл дээр 1000 орчим ном, сэтгүүлтэй болсон бөгөөд нийт 303 төрлийн 543 ширхэг ном, сэтгүүлээр фондоо баяжуулан, номыг нэг бүрчилэн бүртгэлд бүртгэж, ном, судалгааны тайлангийн мэдээллийг электрон каталогид

		ажлыг үргэлжлүүлэх		оруулж, интернэтийн хайлтын системд байршуулав. Судалгааны төвийн 2014 онд хийсэн нийт 9 судалгааны тайланг фондод нэгтгэв. “Төрийн мэдээлэл” сэтгүүлийн 2015 оны №1-19, №26-36 дахь дугаарын мэдээлэл бэлтгэж уншлагын танхимд байрлуулав. Шинэ номын мэдээг нийт 10 номоор гаргаж мэдээллийн самбарт байрлуулав. Нийт 37 төрлийн номоор Уншлагын танхимд шинэ номын үзэсгэлэн гаргасан. “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн 2014 оны №1-4, 2015 оны №1, “Гэмт явдалтай тэмцэх асуудал” сэтгүүлийн 2014 оны № 2,4 дугааруудаар санамж өгөх ном зүй бэлтгэж танхимд байрлуулсан. Уншлагын танхимаар давтагдсан тоогоор нийт 4378 уншигчид 1928 төрлийн 6498 ширхэг ном, үүнээс монгол хэл дээр 3808 ширхэг, англи хэл дээр 183 ширхэг, орос хэл дээр 16 ширхэг ном, гарын авлага олгож үйлчилсэн. Нийт 295 уншигчид шинээр уншигчийн эрх нээж, мөн сунгалт хийсэн болно. МУИС-ийн Хууль зүйн сургууль зэрэг хууль зүйн зарим их, дээд сургууль руу эрдмийн зэрэг горилсон бүтээл ирүүлж, хамтран ажиллах талаар албан бичиг хүргүүлсэн. Шинэ ном хүсэх тухай албан бичгийг Шүүхийн ерөнхий зөвлөл рүү явуулсны дүнд хамтран ажиллав. Номын сангийн нийт номын тооллого явуулав. Уншигч, зохиогч, номын сангийн эргэх холбоог сайжруулах зорилгоор "social media" -г ашиглан уншигч, судлаачдыг шинэ номын мэдээлэл, номын сангийн зарим үйлчилгээгээр хангах ажлыг тогтмолжуулсан байна. 288 төрлийн ном, гарын авлага, сэтгүүлээр номын сангийн уншлагын танхимд болон facebook хуудсанд мэдээ бэлтгэн гаргасан. 12 дугаар сарын 15-ны байдлаар номын сангийн facebook хуудас 1206 дагагчтай, 7 хоног бүр дагагчдын тоо 45 орчмоор нэмэгдсэн байдлаар тогтмол хандалттай байна. Номын сангийн twitter хуудас https://twitter.com/library_HZUH/-ын дагагчдын тоо 549-д хүрээд байна.
БУСАД АЖИЛ				
1		Бодлогын баримт	100	Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан,

	Захиргааны өгсөн үүрэг, даалгавар болон цаг үеийн шинжтэй бусад ажил	бичгийн болон төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, статистик мэдээ		Бодлогын судлаач Б.Гончигсумлаа нар судалгааны төвийн ажлын статистик мэдээ, улирал, жилийн тайлан болон бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн ба Хууль зүйн сайдаас өгсөн албан үүрэг даалгаврын биелэлтийн тайланг нэгтгэн боловсруулах ажлыг хариуцаж ажиллав.
2		Судалгааны цахим сан		Бодлогын судлаач Б.Гончигсумлаа Судалгааны төвийн гүйцэтгэсэн судалгааны ажлуудыг цахим хэлбэрт нэгтгэв.
3		Мэдээ, мэдээлэл		Бодлогын судлаач Б.Энх-Амгалан Хууль зүйн үндэсний хүрээлэн ба түүхэнд гүйцэтгэсэн үүрэг, ач холбогдол сэдвээр олон улсын гэрээ ба бусад бодлогын баримт бичиг болон хүрээлэнгийн үйл ажиллагаа, ажлын үр дүнгийн талаар мэдээлэл бэлтгэв.
4		Захиргааны ерөнхий хуулийн төслийн санал		Бодлогын судлаач Э.Уянга Захиргааны ерөнхий хуулийн төсөлд 6 дугаар сарын 23-25-ны өдрүүдэд санал бэлтгэж өгөв.
5		“Хууль дээдлэх ёс” сэтгүүл-борлуулалт		Бодлогын судлаач Б.Гончигсумлаа Хууль зүйн яамны харьяа агентлаг болон бусад 30 орчим байгууллагад хандаж “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн захиалга, борлуулалтын талаар албан бичиг боловсруулж хүргүүлэв. Дугаар бүрийн түгээлт, борлуулалтыг хариуцан ажиллаж байна.
6		Байгууллагын дотоод дүрэм журмыг боловсронгуй болгох		Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан хүрээлэнгийн үйл ажиллагааг боловсронгуй болгох чиглэлээр бодлогын болон бусад баримт бичгийн төсөл, дотоод дүрэм журам шинэчлэн боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах, санал нэгтгэх, хэлэлцэн батлуулах чиглэлээр бусад судлаач, нэгжтэй хамтран ажиллав. Тухайлбал, “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрэм”, “Хөдөлмөрийн дотоод журам”, “Судалгааны төвийн ажиллах журам”, “Хууль дээдлэх ёс сэтгүүлийн журам”, “Нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”, “Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж, ур чадварын нэмэгдэл олгох журам” зэрэг болно.
7		“Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн контент орчуулга	100	Бодлогын судлаач Э.Туулайхүү Хууль дээдлэх ёс сэтгүүлийн 2015 оны №1,2 (51,52) дугаарт, Бодлогын судлаач Ц.Одгэрэл 2015 оны №3 (53) дугаарт нийтлэгдэх эрдэм шинжилгээний өгүүллийн нэрс болон бусад англи хэл рүү орчуулах шаардлагатай

				хэсгүүдийг орчуулав.
8		Гэрээний төсөл боловсруулах		Бодлогын ахлах судлаач Б. Энх-Амгалан Хууль зүйн үндэсний хүрээлэн, Хууль зүйн яам хооронд байгуулагдсан “Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд боловсруулагдаж буй хуулийн төсөл, батлагдсан хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд хүргэх сурталчилах ажлын гэрээ”-г шинэчлэн боловсруулах төсөл бэлтгэж ХЗЯ-нд хүргүүлэв.
9		Монголын үндэсний радиогийн “Соёмбо” нэвтрүүлэг-хамтын ажиллагаа		Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Монголын үндэсний радиогийн “Соёмбо” нэвтрүүлгийн шууд эфирт ажиллаж “Хөдөлмөрийн аюулгүй байдал ба эрүүл ахуй” сэдвээр олон улсын болон дотоодын эрх зүйн орчин, практик асуудлаар мэдээлэл хийж, иргэдийн асуултад хариулав.
10		Зочин судлаач - хамтын ажиллагаа		Бодлогын судлаач Э.Туулайхүү АНУ-ын Канзасын Их сургуулийн хуулийн сургуулиас Хууль зүйн хүрээлэнд 2015 оны 5 дугаар сарын 22-оос эхлэн 6 долоо хоногийн турш судалгаа, дадлага хийхээр ирсэн Coody Wood, Caroline Dale нарыг судалгааны ажилд оролцуулах болон судалгаа хийхэд шаардлагатай монгол ном зүйгээр хангах ажлыг хариуцаж ажиллав.
11		“Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах” төсөл ба хамтын ажиллагааны уулзалт	100	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар болон ЖАЙКА-ийн “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах” төслийн удирдлагын төлөөлөл 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд айлчилж, Монгол Улсад эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах төсөл хэрэгжүүлсэн ажлын үр дүнг дүгнэсэн уулзалтад Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан оролцож, Монгол Улсад эвлэрүүлэн зуучлалын тогтолцоог нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага, үндэслэл болон хэрэгжилтийн талаар хийсэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судалгааны ажлууд, тэдгээрийн үр дүнгийн талаар мэдээлж, цаашид энэ чиглэлээр дангаар ба бусадтай хамтрах, зохицуулан холбох байдлаар ажиллах боломжийн тухайд санал

			илэрхийлэв.
12		ХЗҮХ болон Макс Планкийн Гадаад болон олон улсын эрүүгийн эрх зүйн институтийн хамтын ажиллагааны хүрээнд	ХБНГУ-ын Макс-Планкийн институтын Гадаадын болон олон улсын эрүүгийн эрх зүйн институт болон Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хамтын ажиллагааны хүрээнд цахимаар харилцах, эрдэм шинжилгээний семинар зохион байгуулах бэлтгэл ажлыг хангах, илтгэл бэлтгэх, материал орчуулах, семинар зохион байгуулалтын талаарх нийтлэлийг “Хууль зүйн мэдээ” сонинд байршуулах, англи хэл дээр бэлтгэх, хурлын талаарх тайлан боловсруулах, сонинд мэдээ өгөх, илтгэлийн эмхэтгэлийг хэвлэн гаргахтай холбоотой ажлыг бодлогын судлаач Б.Ундрах, Ц.Одгэрэл нар хариуцаж ажиллав.
13		Хүний нөөцийн бодлого, үйл ажиллагаа	Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захиргаанаас өгсөн чиглэлийн дагуу, холбогдох журмыг үндэслэн ажилтнуудын ажилласан жил, хүрсэн үр дүн, амжилт бүтээлийг хэлэлцэж, шагналд нэр дэвшүүлэх саналыг захиргаанд уламжлав. Захиргааны хэлтсээс ХЗЯ-нд хандсаны дагуу Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, Бодлогын судлаач Б.Одонгэрэл нар “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдэг, номын сангийн менежер, судлаач Х.Ариунсүрэн, Бодлогын судлаач Э.Уянга, бодлогын судлаач Ц.Одгэрэл нар ХЗЯ-ны “Хүндэт жуух” –аар тус тус шагнагдав.
14		Номын сангийн цахим хуудас хөтлөлт	Бодлогын судлаач Б.Гончигсумлаа, номын сангийн менежер, судлаач Х.Ариунсүрэн нар Судалгааны төвийн номын сангийн вэб хуудас, facebook, twitter хуудсыг тогтмол хөтөлж байна.
15		Номын сангийн үйл ажиллагааг сайжруулах	Номын сангийн менежер, судлаач Х.Ариунсүрэн “Номын сангийн ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулж, номын сангийн шинэчилсэн цагийн хуваарийг батлуулан ажиллаж байна.
16		Архив, албан хэрэг хөтлөлт	Хууль зүйн яам болон бусад байгууллагаас ирүүлсэн албан бичигт хугацаанд нь хариу өгөх, холбогдох мэдээлэл, санал боловсруулах ажлыг бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан хариуцаж ажиллав. Архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт бэлтгэх ажлын хүрээнд нэгжийн холбогдох албан бичиг, судалгааны сан,

			архив бүрдүүлэлтийн чиглэлээр нийт бүрэлдэхүүн ажиллав.
17		ХЗҮХ-ийн эрдэм шинжилгээний ажлын талаар Legalinfo.mn-д мэдээ бэлтгэх, олон нийтэд мэдээ түгээх	Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, бодлогын судлаач Б.Гончигсумлаа нар Хууль зүйн судалгааны төвийн үйл ажиллагаа, ажлын үр дүнгийн талаар Legalinfo.mn зэрэг сайтад мэдээ бэлтгэн, олон нийтэд хүргэх ажлыг хариуцан ажиллаж байна.

Дүгнэлт

Хууль зүйн судалгааны төв нь үйл ажиллагаандаа Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, “Хууль зүйн салбарын нээлттэй бодлого” зэрэг бодлогын баримт бичгүүд болон ХЗЯ-ны 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэргийг удирдлага болгон хэрэгжүүлж ажиллалаа. Тайлант хугацаанд судалгааны төвийн ажлын гүйцэтгэл нь бодлогын ба бусад судалгаа-12, судлаачийн санал, зөвлөмж-8, баримт бичгийн төсөл-7, ном, гарын авлага, сэтгүүл -11, эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэл, нийтлэл-12, зохион байгуулсан болон оролцсон эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэг, сургалт болон бусад арга хэмжээ-28, захиргаанаас өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн шинжтэй багц ажил, үйлчилгээ -17 гэсэн тоон үзүүлэлттэй байна.

Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийг гүнзгийрүүлэх, хууль тогтоомжийг цэгцлэн сайжруулахад эрдэм шинжилгээний ажлыг чиглүүлэн чанар, үр нөлөөг дээшлүүлэх, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаагаар дэмжлэг үзүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг эргэлтэд оруулж, эрх зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны ажилд ашиглах, үйл ажиллагаа, чиг үүргийн хүрээнд эрдэмтэн судлаач, бодлого боловсруулагч, хуульчид, мэргэжилтнүүд ба олон нийтийн дунд байх хандлага баримталж ажиллалаа.

Номын сангийн үйл ажиллагааны өдөр тутмын хэвийн ажиллагааг бүрдүүлж ажилласнаас гадна номын сангийн фондыг баяжуулах, уншигч, зохиогч, номын сангийн эргэх холбоог сайжруулах зорилгоор "social media" -г ашиглан уншигч, судлаачдыг шинэ номын мэдээлэл, номын сангийн зарим үйлчилгээгээр хангах чиглэлээр анхаарч ажилласан.

Судалгааны тоо, хугацааны асуудлаас гадна чанарын асуудал чухал ба хүний нөөцийн хэрэгцээ, шаардлага байгаа талаар Захиргаанд уламжлав. Судалгааны ажлын бүтээгдэхүүнийг эргэлтэд оруулж, эрх зүйн сургалт болон мэдээлэл, сурталчилгааны эх сурвалж болгох зэргээр арга хэмжээ авч ажилласныг тайланд дэлгэрэнгүй тусгав. Цаашид

судалгааны тайлан, хүрсэн үр дүнг "social media" ашиглан олон нийтэд сурталчилан таниулах ажлыг түлхүү анхаарах болно.

ТАЙЛАН ГАРГАСАН :

СУДЛААЧ

Х.АРИУНСҮРЭН
Ж.АРИУНЦЭЦЭГ
Ж.БАРИАШИРСҮРЭН
Б.ГОНЧИГСУМЛАА
Ц.ОДГЭРЭЛ
Б.УНДРАХ
Э.УЯНГА
Б.ЭНХ-АМГАЛАН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

СУДЛААЧ

Б.ГОНЧИГСУМЛАА

ТАЙЛАН ХЯНАСАН:

АХЛАХ СУДЛААЧ

Б.ЭНХ-АМГАЛАН

ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГААНЫ ТӨВИЙН 2015 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН АЖЛЫН ТАЙЛАН

НЭГ. ХУУЛЬ ЗҮЙН СУРГАЛТЫН АЖИЛ¹

1.1.Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн үйл ажиллагааны журам боловсруулж, батлуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 6.1)

Сургалтын төв болон мэдээлэл, сурталчилгааны төв нь бүтцийн өөрчлөлтөөр нэгтгэн зохион байгуулагдсан бөгөөд төвийн үйл ажиллагаа жигдэрч, ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн батлуулсны дагуу төвийн ажиллах журмыг Хууль зүйн үндэсний хүрээлэгийн захирлын 2015 оны 10 дугаар сарын 7-ны өдрийн А/16 дугаар тушаалаар батлуулсан.

1.2.Хуульчдын шалгалтыг зохион байгуулахад оролцож уг шалгалтад бэлтгэх сургалтыг зохион байгуулах, гарын авлагыг шинэчлэн боловсронгуй болгох (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 7.1)

- 2015 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж төлөвлөгөөний дагуу Хуульчийн мэргэжлийн шалгалтыг амжилттай зохион байгуулсан.

- Хуульчийн мэргэжлийн шалгалтын журамд заасны дагуу ажлын тайлан, илтгэх хуудсыг тусгайлан бэлтгэж Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

- Хуульчийн мэргэжлийн шалгалтад зориулсан бодлого бодох аргачлалын сургалтыг 2015 оны 8 дугаар сарын 20-21, 27-28; 9 дүгээр сарын 3-4, 10-11, 14-15-ны өдрүүдэд, 5 удаагийн 60 цагийн сургалтыг зохион байгуулсан. Нийт 253 эрх зүйч хамрагдсан.

- Хуульчийн мэргэжлийн шалгалтын жишиг сорилгын хураамж номыг шинэчлэн боловсруулж өмнөх жилийн зарим алдааг засан шинэчлэн хэвлүүлсэн.

1.3.Хууль зүйн англи хэлний гүнзгийрүүлсэн, эрчимжүүлсэн сургалтыг хөтөлбөрийн дагуу зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 8.1)

2015 оны 5 дугаар сарын 5, 6, 7, 8, 12, 13, 14, 15, 19, 20, 21, 22, 26, 27, 28, 29, 6 дугаар сарын 2, 3-ны өдрүүдэд Хууль зүйн англи хэлний 1, 2 дугаар ээлжийн 36 цагийн сургалтыг зохион байгуулсан. Нийт 48 хуульч хамрагдсан. Хууль зүйн англи хэлний сургалтын гарын авлагыг боловсруулан сургалтад оролцогчдод өгөв. 2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрүүдэд Хууль зүйн англи хэлний 2 дугаар ээлжийн 16 цагийн сургалтыг зохион байгуулсан. Нийт 17 хуульч хамрагдсан.

Хууль зүйн англи хэлний сургалтын гарын авлагыг боловсруулан сургалтад оролцогчдод өгөв. Сургалтыг жилд хоёр удаа зохион байгуулахаар төлөвлөгөөнд тусгасныг хуваарийн дагуу зохион байгуулсан. Нийт дүнгээр 54 цагийн сургалт зохион байгуулж 68 эрх зүйч, хуульчид хамрагдсан.

¹ Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль 2013 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэнээр хуульчийн үргэлжилсэн сургалтыг зохион байгуулах чиг үүрэг Монголын хуульчдын холбоонд шилжсэн.



/ХЗҮХ, Хуульчдын танхим сургалтад оролцогчдод гэрчилгээ гардуулав./

ХУУЛЬ ЗҮЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРГАЛТ

Аж ахуйн нэгж, байгууллагын хуулийн зөвлөх, менежер хуульчдад хууль зүйн англи хэл дээр орчуулга хийх, Монголын хууль, эрх зүйн актын хэм хэмжээг орчуулах, ялангуяа компани үүсгэн байгуулах баримт бичиг, гэрээ хэлцлийг боловсруулах дадал олгоно.

СУРГАЛТЫН ОНЦЛОГ
Монголын худалдааны практикт өргөн хэрэглэж хэвшсэн эрх зүйн баримт бичиг, загвар худалдааны гэрээ хэлэлцээр дээр тулгуурлан явагдана.

ХУГАЦАА
2015.05.05-аас эхлэх 1 сарын эрчимжүүлсэн сургалт. Хичээл 2 ээлжээр зохион байгуулагдана.
• 1 дүгээр ээлж: Мянмар, Пүрэв гарганын 18:30-20:00 цаг;
• 2 дугаар ээлж: Лхагва, Баасан гарганын 18:30-20:00 цаг.

ШААРДЛАГА

- Англи хэлний дундаас дээш мэдлэгийн түвшинтэй;
- Бие даалтад цаг гаргаж орчуулга хийх бололцоотой;
- Хоцролт, таслалтгүй сургалтыг дуусгах.

СЭДЭВ
Эрх зүйн үйлчилгээний гэрээ; Гэрээний эрх зүй; Компаний эрх зүй; Хуулийн этгээд, компани байгуулах журам, үүсгэн байгуулах баримт бичиг; Хөдөлмөрийн эрх зүй; Оюуны өмчийн эрх зүй; Өрсөлдөөний эрх зүй; Маргаан шийдвэрлэх тогтолцоо; Олон улсын хөрөнгө оруулалтын эрх зүй

ТӨЛБӨР 150.000 ТӨГРӨГ.
Сургалтад шаардлагатай орчуулгын гарын авлага, загвар гэрээ хэлэлцээр, дэвтэр, бол зэрэг багтана.

АМЖИЛТАЙ ТӨГСӨГЧДӨД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОНО.

ХУУЛЬЧДЫН ТАНХИМ

LEGAL ENGLISH TRANSLATION HANDBOOK

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

www.legalinstitute.mn
www.legalinfo.mn
11-312825

www.facebook.com/NLIInstitute
 www.twitter.com/legalinstitute



/ХЗҮХ-ийн 301 тоот танхим 5 дугаар сарын 5-ны өдрөөс 6 дугаар сарын 3-ны өдрүүдэд/

1.4.Магистр болон түүнээс дээш эрдмийн зэрэгтэй хүмүүсээр цуврал лекц уншуулах /Улиралд 1 удаа/ (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 9.1)

Нэг. 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр Эрх зүй ба хөгжил цуврал лекцийн хүрээнд Хууль зүйн ухааны доктор Б.Гүнбилэг “Олон улсын эрх зүй ба үндэсний эрх зүйн харилцан хамаарал: уламжлалт морин уралдаан ба хүүхдийн эрхийн асуудал” сэдэвт лекцийг зохион байгуулсан. Нийт 103 хүн хамрагдсан.



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ЭРХ ЗҮЙ БА ХӨГЖИЛ ЦУВРАЛ ЛЕКЦ - ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Б.ГҮНБИЛЭГ

Хууль зүйн ухааны доктор

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙ БА ҮНДЭСНИЙ ЭРХ
ЗҮЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ:
УЛАМЖЛАЛТ МОРИН УРАЛДААН БА
ХҮҮХДИЙН ЭРХИЙН АСУУДАЛ

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН, ХУУЛЬЧДЫН ТАНХИМ,
2015.03.30, ДАВАА ГАРАГ, 17.00 ЦАГ.



/Хуульчдийн танхим 2015 оны 3 дугаар сарын 30/

Хоёр. 2015 оны 5 дугаар сарын 7-ны өдөр Эрх зүй ба хөгжил цуврал лекцийн хүрээнд Хууль зүйн ухааны доктор О.Мөнхсайхан “Үндсэн хуулийн зарчим тайлбарлах онол, арга зүй: Үндсэн хуульд ёс суртахууны тайлбар хийх замаар хүний эрхийн хамгаалалтыг сайжруулах нь” сэдэвт лекцийг зохион байгуулсан. Нийт 105 хүн хамрагдсан.

ЭРХ ЗҮЙ БА ХӨГЖИЛ
ЦУВРАЛ ЛЕКЦ - ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

О.МӨНХСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор

ҮНДСЭН ХУУЛИЙН ЗАРЧИМ ТАЙЛБАРЛАХ
ОНОЛ, АРГА ЗҮЙ: ҮНДСЭН ХУУЛЬД ЁС
СУРТАХУУНЫ ТАЙЛБАР ХИЙХ ЗАМААР
ХҮНИЙ ЭРХИЙН ХАМГААЛАЛТЫГ
САЙЖРУУЛАХ НЬ



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДСЭНИЙ ХҮРЭЭЛЭН, ХУУЛЬЧДЫН ТАНХИМ,
2015.05.07, ПҮРЭВ ГАРАГ, 17.00 ЦАГ.



/Хуульчдийн танхим 2015 оны 5 дугаар сарын 7/

Гурав. 2015 оны 10 дугаар сарын 23-ны өдөр “Үндсэн хуулийн долоон нэмэлт өөрчлөлт харьцуулсан судалгаа хууль зүйн шинжилгээ” сэдэвт цуврал лекцийг зохион байгуулсан. Нийт 110 хүн хамрагдсан.



/Хуульчдийн танхим 2015 оны 10 дугаар сарын 23/

Дөрөв. 2015 оны 12 дугаар сарын 10-ны өдөр “Үндсэн хуулийн нэмэлт өөрчлөлт: Парламентийн бүрэн эрх” сэдэвт цуврал лекцийг зохион байгуулсан. Нийт 30 хүн хамрагдсан.



/Хуульчдийн танхим 2015 оны 12 дугаар сарын 10/

1.5. “Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх нь” сургалт зохион байгуулах
(ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 10.1)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2015 оны 11 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд сургалтыг боловсруулсан гарын авлага, хөтөлбөрийн дагуу хичээлийн 2 өдөр буюу 16 цагийн “Хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх нь” сэдэвт сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт 20 алба хаагчдыг хамруулан зохион байгуулав. Тус сургалтаар хуульчид, хууль сахиулах байгууллагын алба хаагчдын хүний эрхийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх, хүний эрхэд суурилсан хандлага төлөвшүүлэх зорилготой юм.



/Хуульчдийн танхим 2015 оны 11 дүгээр сарын 17/

1.6. “Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын төсөл боловсруулах аргачлал” сэдэвт сургалт зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 11.1)

2015 оны 3 дугаар сарын 21-ний өдөр “Захиргааны хэм хэмжээ тогтоосон актын төсөл боловсруулах аргачлал” сэдэвт сургалтыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулсан. Сургалтад Нийслэлийн Засаг даргын харьяа 32 хэрэгжүүлэгч агентлаг, 9 дүүргийн эрх зүйн ажилтан, хуулийн зөвлөх 70 гаруй албан хаагч хамрагдсан.



/Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хан-гарьд ордон 3 дугаар сарын 21-ний өдөр/

1.7.Хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг төрийн байгууллагын албан хаагчдад сургалт хийх /I улиралд/ (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 12.1)

“2015 оны 2 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд “Хүйсийн тэгш эрх” ТББ-тай хамтран “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх” нь сэдэвт сургагч багшийн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Дорноговь, Замын-Үүд, Өмнөговь, Дорнод, Сэлэнгэ аймгийн шүүгч, прокурор, цагдаа, тахар, өмгөөлөгч нарыг сургагч багшаар бэлдсэн. Нийт 30 хуульч хамрагдсан.



/УЕПГ-ын сургалт, сурталчилгааны төв 2015 оны 2 дугаар сарын 5, 6-ны өдрүүдэд/

1.8.Захиалгат сургалт

- “Нутгийн удирдлагын нийгэмлэг” ТББ-ын захиалгаар 2015 оны 3 дугаар сарын 20-ны өдөр “Гэрээний эрх зүй” сэдэвт захиалгат сургалтыг зохион байгуулсан. Нийт 20 хүн хамрагдсан.

-

1.9.Бусад сургалт


- НҮБ-ын хүүхдийн сан, Хувь хүний хөгжлийн институттэй хамтран 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрөөс 29-ний өдрүүдэд **“Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын стандарт”** сэдэвт хууль сахиулах байгууллагын алба хаагчид, шүүгч, прокурор, тахар, нийгмийн ажилтнуудад зориулсан үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг

зохион байгуулсан. Нийт 30 хууль сахиулах байгууллагын алба хаагчид, шүүгч, прокурор, тахар, нийгмийн ажилтнууд Үндэсний сургагч багшаар бэлтгэгдсэн.



“Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын стандарт”

Сургагч багш бэлтгэх сургалтын гарын авлага



-
сарын

**1.10.Лекц
хэлэлцүүлэг**
2015 оны 6 дугаар
23-ны өдөр
Захиргааны
ерөнхий хуулийн
танилцуулга,

мэдээлэл хийх уулзалтыг Хуульчдын танхимд зохион байгууллаа. Нийт 105 хүн хамрагдсан.



-2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хуульчдын өдрийг тохиолдуулан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.



(2015.06.26. ХЗҮХ, Хуульчдын танхим)

-2015 оны 7 дугаар сарын 3-ны өдөр Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хуулийн төслийн агуулга, үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт сэдвээр хэлэлцүүлэг, мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.



(2015.07.03. ХЗҮХ, Хуульчдын танхим)

-2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн УБЕГ-тай хамтран “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл”-ийн талаар танилцуулга, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав. Нийт 60 хүн хамрагдсан.



(2015.11.17. ХЗҮХ, Хуульчдын танхим)

1.11.Дотоод сургалт

Дотоод сургалт төлөвлөгөөний дагуу 4 удаагийн сургалтыг зохион байгуулсан.

1. 2015 оны 6 дугаар сарын 12-ний өдөр “Төрийн дипломат ёслол”, “Ёслолын арга хэмжээ зохион байгуулахад анхаарах практикийн зарим асуудал” сэдэвт дотоод сургалтыг зохион байгуулсан. Нийт 18 ажилтан хамрагдсан.

2. 2015 оны 6 дугаар сарын 17-ний өдөр “Мэдээллийн урсгал” сэдэвт дотоод сургалтыг зохион байгуулсан. Нийт 10 ажилтан хамрагдсан.

3. 2015 оны 10 дугаар сарын 10-ны өдөр “Архив, албан хэрэг, хөтлөлт” сэдэвт сургалт зохион байгуулсан . нийт 16 ажилтан хамрагдсан.

4. 2015 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр “Судалгааны арга зүй” сэдэвт сургалт зохион байгуулсан. Нийт 8 ажилтан хамрагдсан.

Төлөвлөгөөний дагуу дотоод сургалтыг улиралд нэг удаа, нийт 4 удаа зохион байгуулсан болно.



(“Архив, албан хэрэг, хөтлөлт” сэдэвт дотоод сургалт)

1.12.Эрх зүйн албан бус сургалт

2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр эрх зүйн албан бус сургалтын хүрээнд “Шинээр батлагдсан хууль тогтоомжийн танилцуулга”, “Монгол Улсын олон улсын гэрээний хэрэгжилт: Хүний эрх” сэдэвт сургалтыг Хөвсгөл аймгийн Мөрөн хотод зохион байгуулсан. Нийт 50 хүн /Хөвсгөл аймгийн сумдын Засаг даргын Тамгын газрын дарга, хороодын зохион байгуулагч болон бусад иргэд/ хамрагдсан. Түүнчлэн тус хүрээлэнгээс эрхлэн гаргасан эрх зүйн мэдээллийн нугалбар хуудас, ном, гарын авлагыг Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын Хуулийн хэлтэст өгөв.



(Хөвсгөл аймаг, Мөрөн хот 2015.06.18-ны өдөр)

ХОЁР. ХУУЛЬ ЗҮЙН МЭДЭЭЛЭЛ, СУРТАЛЧИЛГААНЫ АЖИЛ

2.1.“Хууль зүйн мэдээ” цахим сонинг чанаржуулан, уншигчийн тоог нэмэгдүүлэх, гадаад хэл дээр мэдээ, материал нийтлэх (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 13.1)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн цахим хуудаст Хууль зүйн мэдээ сонины цахим хувилбарын 34 дугаарыг холбосон.

Хууль зүйн мэдээ цахим сонины уншигчдын тоо өссөн үзүүлэлттэй байна. Хууль зүйн мэдээ цахим сонины №25 /337 хүн үзсэн/, №26 /308 хүн үзсэн/, №27 /331 хүн үзсэн/, №28 /323 хүн үзсэн/, №29 /230 хүн үзсэн/, №30 /254 хүн үзсэн/ мөн Хуульчдын өдөрт зориулсан тусгай дугаар Хууль зүйн мэдээ цахим сонины №30-ыг хэвлэмэл байдлаар гарган хэвлэл, мэдээллийн болон, төрийн байгууллагуудад тараав. Сонины №31/277 хүн үзсэн/, Хууль зүйн мэдээ сонины англи хэл дээрх тусгай дугаар №32/277 хүн үзсэн/, Үндсэн хууль нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотойгоор тусгайлан сэдэвчлэн бэлтгэсэн дугаар №33/277 хүн үзсэн/, 2015 оны хууль зүйн салбарын онцлох үйл явдлуудаар бэлтгэсэн тусгай дугаарыг хэвлэмэл байдлаар гарган Хууль зүйн яамны харьяа агентлаг байгууллагууд, бусад төрийн байгууллагуудад тараав. Мөн сонины цахим хувилбар №34/277 хүн үзсэн/ байна.

Нийт жилд 12 дугаар, сард нэг дугаар бэлтгэн гаргахаас бүгдийг бэлтгэн гаргаж уншигчдад хүргүүлсэн болно.



(Хууль зүйн мэдээ сонин Хуульчдын өдрийг тохиолдуулан гаргасан дугаар №30)

2015 оны эхний хагас жилийн байдлаар тус цахим сонин **3500 гаруй** уншигчдад хууль, эрх зүйн мэдээлэл хүргэсэн байна.

2.2.Иргэдэд зориулсан эрх зүйн мэдээлэл түгээх цахим хуудас бий болгох ажлын хүрээнд цахим хуудасны бүтэц, агуулгын төсөөллийг боловсруулна. (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 14.1)

Иргэдэд зориулсан эрх зүйн мэдээлэл түгээх цахим хуудас бий болгох ажлын хүрээнд цахим хуудасны агуулгын төсөөллийг боловсруулсан. Энэ нь иргэдийг насны болон нийгмийн бүлэгт ангилан эрх зүйн мэдээллийг тухайн бүлгийн онцлогт зориулан бэлтгэх, түгээх

зорилготой цахим хуудас юм. Тус цахим хуудсыг хийх ажилд ойролцоогоор 2,5-4,5 сая төгрөгийн зардал орох зах зээлийн судалгаа хийгдсэн ба тогтвортой, шуурхай ажиллуулахад 2-3 хүн шаардлагатай. Төсөвт эдгээр зардлууд суусан тохиолдолд ирэх оны төлөвлөгөөнд оруулан хэрэгжүүлэх боломжтой ажил юм.

2.3.Сэтгүүлчдийн дунд хэрэгцээт болон салбарын шинэчлэлийн цаг үеийн асуудлаар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 15.1)

-2015 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар хуульчид, өмгөөлөгчдийн санал солилцсон хэлэлцүүлэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгуулав.

-2015 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Захиргааны ерөнхий хуулийн танилцуулга, мэдээлэл хийх уулзалтыг Хуульчдын танхимд зохион байгууллаа. Нийт 105 хүн хамрагдсан.

-2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хуульчдын өдрийг тохиолдуулан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.

-Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хуулийн төслийн агуулга, үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт сэдвээр хэлэлцүүлэг, мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.

-2015 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэн УБЕГ-тай хамтран “Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн төсөл”-ийн талаар танилцуулга, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулав. Нийт 60 хүн хамрагдсан.

Эдгээр хэлэлцүүлэг, танилцуулга, мэдээллийг зохион байгуулахдаа хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнууд, сэтгүүлчдэд мэдээлэл хүргэж, мэдээ, сурвалжлага ярилцлага өгсөн болно.

2.4.Гэр бүлийн радио 104,5-тай хамтран ажиллах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 16.1)

Гэр бүлийн радио 104,5-ын “Харах өнцөг” хууль эрх зүйн нэвтрүүлэгт хамтран ажиллаж, нэвтрүүлгийн дугааруудад оролцох хуульч, өмгөөлөгчидтэй холбож өгч, мэдээлэл бэлтгэх байдлаар хамтран ажиллав.

2.5.Эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаанд facebook.com, twitter.com хуудсыг идэвхтэй ашиглах, хөгжүүлэх (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 17.1)

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн twitter, facebook хуудсыг хариуцан үйл ажиллагааны мэдээллийг цахим орчинд байршуулж байна. Тус цахим хуудаснуудын дагагчдын тоо



тасралтгүй өссөн үзүүлэлттэй байна. Тухайлбал, фэйсбүүк хуудасны лайкын тоо 2015 оны 3 дугаар сарын байдлаар 4100 байсан бол 12 дугаар сарын байдлаар 4800 болж өссөн байна. Твиттер хуудасны дагагчийн тоо 2015 оны 5 дугаар сард 871 байсан бол 12 дугаар сарын байдлаар 1700 болж өсчээ.

2.6.ЕБС-ийн сурагчдад хийх сургалтын хөтөлбөр, аргачлал боловсруулах, батлуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 18.1)

2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр “Шинэ Монгол” сургуулийн төгсөх ангийн нийт 200 орчим сурагчдад, хуульч мэргэжлийн тухай болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар мэдээлэл хийв.

2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нийслэлийн 31 дүгээр сургуулийн 10 дугаар ангийн 3 бүлгийн 100 гаруй сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдээлэлтэй байхын ач холбогдол болон хууль, эрх зүйн мэдээллийг хаанаас олж авах талаар уулзалт, мэдээллийг хийлээ.

2015 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр нийслэлийн 31 дүгээр сургуулийн 10 дугаар ангийн 3 бүлгийн 100 гаруй сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдээлэлтэй байхын ач холбогдол болон хууль, эрх зүйн мэдээллийг хаанаас олж авах талаар уулзалт, мэдээллийг хийлээ.

2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр мөн нийслэлийн 31 дүгээр сургуулийн 6, 7, 8, 9 дүгээр ангийн 3 бүлгийн 200 гаруй сурагчдад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, эрх зүйн мэдээлэлтэй байхын ач холбогдол болон хууль, эрх зүйн мэдээллийг хаанаас олж авах талаар уулзалт, мэдээллийг хийлээ.

2.7.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалт, уулзалт зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 19.1)

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн тусгай 29 дүгээр сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчдад 2015 оны 5 дугаар сарын 11-ний өдөр эрх зүйн мэдээлэл олж авах, эрх зүйн мэдээлэлтэй байхын ач холбогдол болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгуулж, хичээл оров.



Сонсголгүй иргэдийн мэдээллийн төв болон Дохион хэлмэрч, орчуулагчдын холбоотой хамтран 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр сонсголгүй иргэдийн дунд “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх, хөдөлмөрлөх эрх хэрэгжил, эрх зүйн зохицуулалтын талаар” сургалт зохион байгууллаа. Тус сургалтад 20 гаруй иргэд оролцсон.

2.8.Эрх зүйн мэдээлэл хэрхэн бэлтгэх, түгээх зэрэг асуудлын хүрээнд нэг бүрчлэн аргачлалыг боловсруулан аргачлалыг нэвтрүүлэх сургалт уулзалтыг хийх (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 20.1)

2015 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд Хууль зүйн яамны харьяа агентлаг, байгууллагын эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад “Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлал, цаашдын зорилт” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

-Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлалыг боловсруулж Хууль зүйн яаманд санал, чиглэл авахаар хүргүүлсэн.

-Хууль зүйн яамнаас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийн дагуу цаашид сэтгүүлчид, эрх зүйн сургалт сурталчилгаа хариуцсан ажилтнуудад аргачлалын хүрээнд хичээл бэлтгэн орох, аргачлалыг хэвлэх, холбогдох мэргэжилтнүүдэд хүргэх ажлыг зохион байгуулахаар төлөвлөөд байна.

2.9.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шинээр батлагдах хуулиудыг сурталчлах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 21.1)

-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Прокурорын байгууллагын тухай, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Нийслэл хотын албан татварын тухай, Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль, хуулийн төслийн талаарх танилцуулга, үзэл баримтлалын талаарх мэдээлэл бэлтгэн “ТВ-Зоне” сэтгүүлд нийтлүүлсэн /ТВ-Зоне” сэтгүүл 7 хоног бүр нийтлэгддэг, 20.000 гаруй захиалагч, уншигчтай/.

-2015 оны 6 дугаар сарын 4-ний өдөр Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар хуульчид, өмгөөлөгчдийн санал солилцсон хэлэлцүүлэг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд зохион байгуулав.

-2015 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Захиргааны ерөнхий хуулийн танилцуулга, мэдээлэл хийх уулзалтыг Хуульчдын танхимд зохион байгууллаа. Нийт 105 хүн хамрагдсан.

-2015 оны 6 дугаар сарын 26-ны өдөр Хуульчдын өдрийг тохиолдуулан Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийн талаар мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.

-Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хуулийн төслийн агуулга, үзэл баримтлал, шинэлэг зохицуулалт сэдвээр хэлэлцүүлэг, мэдээлэл, танилцуулга хийх ажлыг зохион байгуулав. Нийт 50 хүн хамрагдсан.

-Эрүүгийн хууль шинэчлэн батлагдсан болоод хэрэгжиж эхлэх хугацааны талаар танилцуулга видео шторк бэлтгэсэн.

-Гэр бүлийн хүчирхийлэлийн эсрэг хуулийн төслийн 3 танилцуулга шторкийг байгууллагын эрх зүйн сурталчилгааны ЛЭД дэлгэцээр тогтмол давтамжтайгаар нэвтрүүлж байна.

-Эрүүгийн хуулийн гол онцлог, шинэлэг зохицуулалтын талаарх мэдээлэл бүхий зурагт хуудас бэлтгэж цахим хуудсаар мэдээллийг түгээсэн.

2.10.Салбарын хууль тогтоомжийг сурталчлах ажлын хүрээнд Хууль зүйн яамтай хамтран эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа хариуцсан ажилтнуудад сургалт, семинар зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 22.1)



2015 оны 3 дугаар сарын 16-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хуульчдын танхимд ХЗЯ-ны харьяа агентлаг, байгууллагын эрх зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгаа хариуцсан албан тушаалтан болон, мэргэжилтнүүдэд зориулсан сургалт, семинарыг ХЗЯ-тай хамтран зохион байгуулж Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн эрхлэгч Э.Өнөрбаяр “Хууль тогтоомж эмхэтгэж ирсэн түүхэн уламжлал, орчин үеийн чиг хандлага”, мэргэжилтэн Г.Билгүүн “Эрх зүйн мэдээлэл бэлтгэх, түгээх аргачлал, цаашдын зорилт” сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.

ХЗМССТ-ийн эрхлэгч А.Түвшинтулга 2015 оны 9 дүгээр сарын 24-ний өдөр аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн мэргэжилтнүүдэд “Эрх зүйн актыг системчлэх арга” сэдвээр хичээл заав.

2.11. “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn/-ийн үйл ажиллагааны найдвартай хэвийн ажиллагааг хангаж ажиллах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 23.1)

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Үндэсний дата төв ТӨҮГазарт байрших серверийн гадаад хаягийг солих ажлыг зохион байгуулсан.

“Интерактив” ХХК-тай хамтран ажиллах гэрээ, санамж бичиг байгуулан ажиллаж, www.legalinfo.mn сайтын дизайн болон холбогдох цэснүүд иргэдэд илүү ойлгомжтой болж хэрэглэхэд хялбар болгож шинэчлэлийг хийв.



(Хуучин хувилбар)

(2015 оны VI сар шинэчлэгдсэн хувилбар)

www.legalinfo.mn цахим хуудсанд 2015 оны 12 дугаар сарын байдлаар **1314524** хэрэглэгч, **9807189** удаа хандсан үзүүлэлттэй байна.

www.legalinstitute.mn цахим хуудсанд 2015 оны эхний 12 сарын 25-ны өдрийн байдлаар төрийн байгууллага, хууль зүйн салбарт болж буй үйл явдал, хууль зүйн холбогдолтой **170** мэдээ, материалыг нийтлэв.

www.legalinfo.mn цахим хуудсанд 2015 оны эхний 12 сарын байдлаар төрийн байгууллага, хууль зүйн салбарт болж буй үйл явдал, хууль зүйн холбогдолтой **112** мэдээ, материалыг нийтлэв.

Тухайлан Эрх зүйн хөгжил буланг ажиллуулж мэдээллийг байнга шинэчлэн ажиллаж байна.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /www.legalinfo.mn цахим хуудас/-ийн алдаа мэдээлэх буланд ирсэн **22 санал, хүсэлтийн** хариуг имэйлээр илгээн явуулсан ба 11-312513

утсанд хэрэглэгчдээс ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч, тэдний тавьсан асуултанд зохих хариуг цаг тухай бүрд нь шийдвэрлэн өгч ажиллав.

2.12.ЭЗМНС-д дутуу байгаа актыг зохих журмын дагуу бүрдүүлж ажиллах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 23.3)

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд байгаа эрх зүйн актуудыг хянах ажлыг өдөр тутамдаа зохион байгуулан ажиллаж байна. Эдгээрт дутуу болон хэлбэржилт алдаатай актуудыг эх хувьтай тулгах, холбогдох байгууллагуудаас асуух зэргээр тодруулан ажилласан.

Тоон үзүүлэлтээр харуулбал:

Д/д	Төрөл	Тоо хэмжээ
Хууль		
1	Хэлбэржилт зассан хууль /хүчинтэй/	104
2	Хүчингүй болсон хуулийг нэмж оруулсан	1
3	Хэлбэржилт зассан хүчингүй хууль 1963, 1986-1999	105
Засгийн газрын тогтоол		
4	Засгийн газрын 2014 оны тогтоолд хяналт хийсэн	405
Монгол Улсын Дээд шүүхийн зөвлөмж		
5	Дээд шүүхийн зөвлөмжийн /иргэн, эрүү/ хэлбэржилтийг зассан	33
Яам болон агентлагын тушаал		
6	Хэлбэржилт зассан тушаал	100
7	Хянасан тушаал	758
Нийт		1506

2.13. 1994 оноос хойш батлагдсан нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудын хуулбар хувийг цэгцлэн мэдээлэл хайхад хялбар болгох (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 24.1)

Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдэн, манайд цаасан хувиар хадгалагдаж байгаа нийтээр дагаж мөрдөх эрх зүйн актуудыг 1991 оноос эхлэн бүгдийг цэгцлэн, дутуу актыг нөхөн оруулж, ашиглахад хялбар болгон архивын стандартын дагуу архивласан /Улсын бүртгэлийн дугаар 258-3507 хүртлэх, нийт 118 хавтас/.

2.14.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраар дамжуулан засаг захиргааны анхан, дунд шатны нэгж, байгууллага бүрээр захиалуулах арга хэмжээг авах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 25.1)

“Хууль зүйн мэдээлэл” эмхэтгэлийн тоог нэмэгдүүлэх үүднээс Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэг /2015.03.26 01/100/, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл /2015.03.26 01/101/, МҮХАҮТ-ын удирдах зөвлөлийн дарга бөгөөд ерөнхийлөгч Б.Лхагважав /2015.03.26 01/102/, ХЗЯ-ны БХЗГ-ын дарга Б.Үнэнбат тус хүрээлэнгийн үйл ажиллагаатай танилцах үеэр засаг захиргааны анхан, дунд шатны нэгж, байгууллага, ХЗЯ-ны харьяа агентлаг байгууллагуудаар захиалуулах ажлыг санал болгосон албан бичиг боловсруулан хүргүүлсэн.

2.15.Ухаалаг гар утсанд зориулсан “legalinfo” програмын үйл ажиллагааг идэвхжүүлэх (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 25.3)

Ухаалаг гар утсанд зориулсан “Legalinfo” програмын хуулийн шинэчлэл, мэдээллийн шинэчлэлийг хийж байна. Хэрэглэгчийн тоог нэмэгдүүлэх үүднээс сурталчилгааг LED, LCD дэлгэц, цахим хуудсуудаар дамжуулан түгээж байна. “legalinfo” програмыг гар утаснаас ашиглахад хялбар болгож шинэ дизайн боловсруулан хэрэглээнд нэвтрүүлсэн.

Ухаалаг гар утсанд зориулсан legalinfo аппликейшны хуулиудыг оруулах мэдээллийг шинэчлэх, хэрэглэгчийн тоог ихэсгэх ажлыг хийж гүйцэтгэн ажиллаа. Одоогоор android 50,000+, iOS 30,000+ хэрэглэгчтэй болоод байна.

2.16.Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны лэд дэлгэцийн үйл ажиллагааг идэвхжүүлэх (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 25.2)

Хууль зүйн мэдээлэл, сурталчилгааны ЛЭД дэлгэцийн өдөр тутмын үйл ажиллагааг хангаж ажиллаж байна. Бизнесийн байгууллага болон хуулийн нөхөрлөлүүд рүү хамтран ажиллах албан бичиг илгээв. МТА, “Өдрийн сонин”, “Хууль сахиулахын их сургууль”, “Тахарын алба”, “Говь Хангай” мебель зэрэг байгууллагуудын видео шторкийг төлбөртэйгээр түгээв.

Бизнесийн байгууллагатай “Хамтран ажиллах тухай” албан тоот төлөвлөн Арилжааны банк, Үүрэн оператор, Үндэсний үйлдвэрлэгч компани, Монголын болон гадаадын хөрөнгө оруулалттай ХХК нийт 30 байгууллагын маркетингийн албанд хүргэсэн.

Хууль зүйн сургалт, сурталчилгааны ЛЭД дэлгэцийг хэвийн үйл ажиллагааг ханган ажиллаж өдрийн турш 08.00-20.00 цагийн хооронд 15 төрлийн видео шторкийг 150 удаагийн давталтайгаар түгээж байна. Тайлангийн хугацаанд нийт 65 төрлийн видео шторкийг түгээсэн.

2.17.ЭЗМНСанг интернетгүй үед хэрэглэх хувилбар буюу DVD-нд буулгах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 23.5)

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг CD хувилбарыг худалдаанд гаргах ажлын бэлтгэл ажлыг хийсэн. Үндсэн кодыг CD-нд хуулсанаар хамгаалах боломж багасаж алдагдах эрсдэл үүсэхээр байгаа тул CD хувилбарыг хойшлуулсан болно.

2.18. Иргэдийн эрх зүйн мэдлэгт зориулсан “Хөдөлгөөнт цэг”-ийн үйл ажиллагааг зохион байгуулах (ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний 26.1)

Хууль зүйн яамтай хамтран тухайлсан төлөвлөгөө удирдамжийн дагуу хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Энэ ажлын хүрээнд хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээний зохион байгуулалтыг ХЗЯ-тай хамтран хийж тус үйл ажиллагаанд ХЗҮХ-ээс оролцох оролцоог ханган нийслэлийн 6 дүүрэг, алслагдсан 3 дүүрэгт биечлэн оролцож зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр удирдамжид заасны дагуу тус хүрээлэнгийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээг иргэдэд хүргэх ажлыг хийв. Энэ хүрээнд эрх зүйн мэдээллийг иргэдэд хүргэж буй арга хэлбэрийн талаар нийт 500 иргэнээс санал, асуулга авав. Түүнчлэн иргэдийн хуулийн мэдлэгт зориулсан 16 нэр төрлийн хялбаршуулсан нугалбар хуудас ойролцоогоор 6000 орчим ширхэгийг иргэдэд тарааж мэдээлэл хүргэв.



2.19. Хууль зүйн мэдээлэл сурталчилгааны чиглэлээр хийсэн бусад ажил

- ТВ-Зоне сэтгүүлд 7 хоног бүр мэдээ материал бэлтгэн нийтлүүлж байна. Нийт 48 материал бэлтгэн тус сэтгүүлд хэвлүүлэв.

- SBN телевизийн 7/17 өдрийн хөтөлбөртэй хамтран ажиллахаар тохиролцон “Хуулийн цаг” буланг ХЗҮХ-ээс хариуцан ажиллаж байна. Өнөөдрийг хүртэл 8 удаагийн булангаар /1 удаа 40 минут/ зочин оруулж зөвлөгөө, мэдээлэл өгүүлэв.

- Казак хэл дээр хэвлэгддэг “Тарлан Тагзым” сэтгүүлтэй хамтран ажиллаж тус сэтгүүлд эрх зүйн мэдээлэл нийтлүүлж байна. Улиралд нэг удаа материал бэлтгэн нийтлүүлнэ.

- 2015 оны 2 дугаар сард НЗДТГ болон нийслэлийн харьяа байгууллагуудын сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтнүүдэд /нийт 50 орчим/ “Эрх зүйн мэдээлэл, сурталчилгаа” сэдвээр мэдээлэл хийв.

- Royal телевизэд “Хуулийн цаг” теле сериалын цувралыг гаргуулахаар тохиролцож шилжүүлэн өгөв.

- МҮОНР-ийн Дэгдээхэй нас шууд нэвтрүүлэгт оролцож “Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн эрх зүйн орчин сэдвээр ярилцлага өгөв.

- Хууль, түүнийг хэлбэрэлтгүй сахих, хуулийн мөн чанар зэрэг агуулгатай гадаадын болон дотоодын нэртэй сэтгэгчдийн хэлсэн үгээр постер бэлтгэж байна.

- Хууль тогтоомж сурталчлах нэгдсэн арга хэмжээний зохион байгуулалтыг хийж тус үйл ажиллагаанд ХЗҮХ-ээс оролцох оролцоог ханган нийслэлийн 6 дүүрэг, алслагдсан 3 дүүрэгт биечлэн оролцож зохион байгуулав.

- Хуульчдын өдрийг зохион байгуулан, тэмдэглэх ажлыг зохион байгуулав. Энэ ажлын хүрээнд Хуульчдын өдрөөр мэдээлэл хүргэх арга хэлбэрүүд болон www.legalinfo.mn сайтын шинэчлэгдсэн хувилбар, Эрүүгийн хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Өмгөөллийн тухай хуулийн төслийн талаар танилцуулга мэдээлэл хийж, Хууль зүйн чиглэлээр хамтран ажилладаг хэвлэл, мэдээллийн байгууллагуудад Хууль сурталчлагч шагнал гардуулах зэрэг ажиллагааг зохион байгуулж ажиллав. “Хууль сурталчлагч түнш” шагналыг Өдрийн сонин, SBN телевиз, www.itoim.mn, “Интерактив” ХХК-т өгөв.

- Хуульчдын өдрөөр зохион байгуулсан арга хэмжээний талаар МҮОНТ, SBN телевиз, Royal телевиз, 25-р суваг телевиз, ETV телевиз, Парламент суваг, Монголын Радио зэргээр хэвлэлийн мэдээ, ярилцлага өгөв.

- Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага ЖАЙКА-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар болон ЖАЙКА-ийн “Эвлэрүүлэн зуучлах тогтолцоог сайжруулах” төслийн удирдлагын төлөөлөл 2015 оны 6 дугаар сарын 18-ны өдөр Хууль зүйн үндэсний хүрээлэнд уулзаж эвлэрүүлэн зуучлалын тогтолцоо, үр ашгийн талаар олон нийтийн ойлголт мэдлэгийг

нэмэгдүүлэх, мэдээлэх, сурталчилан таниулах чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов.

- ХБНГУ-ын Ханнс-Зайделийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, түүний “Эрх зүйн боловсрол” академийн гүйцэтгэх захиралтай уулзаж, Захиргааны ерөнхий хуулийг хэрэгжүүлэх, иргэд, олон нийтэд хүргэх чиглэлээр хамтран ажиллах талаар санал солилцов.



ХУУЛЬ ЗҮЙН ЯАМ



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН



МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО

ХУУЛЬЧДЫН ӨДӨР

Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 7 дугаар сарын 7-ны одоогийн Журал батлах тухай (Түүхэн ой, тэмдэглэл өдөр) 172 дугаар тогтоолны 4.1.18-д “Хуульчдын өдөр жил бүрийн 6 дугаар сарын 4 дэх Ням гараг”-т тэмдэглэж байхаар зоосон. Үүнээс хойш жил бүр уламжлал болгон тэмдэглэж ирсэн.

Арга хэмжээний цэр эрх зүйн холбогдолтой номын үзэсгэлэн, худалдаа гарах болно.

МА БЧХЭНГ ХЧРЭЦЭНГ ИРЖ
ОРОЛЦОНО УУ.

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН
ХУУЛЬЧДЫН ТАНХИМ 10⁰⁰-12⁰⁰ ЦАГТ

Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Өмгөөллийн тухай хуулийн төслийн талаар танилцуулга, мэдээллийг хүргэнэ;


Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем, www.leginfo.mn цахим хуудасны шинэчлэл, эрх зүйн мэдээлэл иргэдэд хүргэх арга хэлбэрийн талаар мэдээлэл хийнэ;

Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран ажилладаг, иргэдийн эрх зүйн мэдээллийг нэлэгдүүлэх, эрх зүйн мэдээлэл хүргэх чиглэлээр ндэвхи, санаачлагатай ажилладаг хэвлэл мэдээллийн байгууллагад “Хууль сурталчлагч түнш-2015” шагналыг гардуулах ажиллагаа тус тус болно.

2015.06.26

Эрх


зүйн мэдээллийг иргэдэд хүргэх чиглэлд ХЗҮХ-тэй хамтран ажилладаг хэвлэл, мэдээллийн байгууллагад “Хууль сурталчлагч түнш” шагналыг гардуулав. Тус шагналыг Өдрийн сонин, SBN телевиз, www.itoim.mn, “Интерактив” ХХК-т олгов. /2015.06.26/



“Тө-

Зоне” сэтгүүлийн 2015 оны

№6, 7 /364, 365/



/Казах хэл дээр хэвлэгдэн гардаг “Тарлан тагзым” сэтгүүл/



SBN телевизийн 7/17 өдрийн хөтөлбөрийн 2015 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн шууд нэвтрүүлэгт /50 минут/ оролцож ХЗҮХ-ээс эрх зүйн мэдээлэл иргэдэд хүргэж буй арга хэлбэр, үйл ажиллагааны талаар болон Захиргааны хариуцлага, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, Захиргааны хэргийн шүүх, Хөдөлмөрийн эрх зүйн асуудлаар иргэдэд эрх зүйн мэдээлэл өгөв.

*/Сошиал медиагаар олон нийтэд хүргэж буй
гадаадын болон дотоодын сэтгэгчдийн хэлсэн үг/*



ГУРАВ. НОМ ТОВХИМОЛ ХЭВЛЭН НИЙТЛЭХ АЖИЛ /ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР/

- Монгол Улсын хууль №22, 2014 оны хууль;
- “Хууль зүйн мэдээлэл” эмхэтгэл 17 дугаар;
- “Хяналт-шинжилгээ, үнэлгээ, санхүүгийн ажилтанд зориулсан эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл;
- Посткоммунист орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага ба Монголын эрх зүйн тогтолцооны төлөвшил, онцлог” ОУБХ-ын эмхтгэл /ҮХЦ, МУИС, ХЗҮХ/;
- Хууль зүйн англи хэлний сургалтын гарын авлага;
- “Хүүхдийн эсрэг хүчирхийлэлд хариу үйлдэл үзүүлэх, насанд хүрээгүй гэрч, хохирогчтой харилцах НҮБ-ын стандарт” сэдэвт сургалтын гарын авлага;
- Их засгийг эрэн сурвалжлах нь /эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл ҮХЦ, МУИС, ИЗИС;
- Автотээвэр /олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл;
- Автотээвэр /эрх зүйн баримт бичгийн эмхтгэл/;
- “Ургамал, хорио цээрийн холбогдолтой олон улсын гэрээ, хэлэлцээрийн эмхэтгэл /ХХАЯ, ХЗҮХ/. Эхийг бэлдэж буй.
- Хуульчийн сорилгын жишиг хураамж 2015 он ном /эх бэлтгэлд шилжүүлсэн/
- Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төслийг Хууль зүйн яамны захиалгаар 200 хувь, Улсын Их Хурлын Тамгын газрын захиалгаар 100 хувийг хэвлэв.
- Хууль зүйн яам, УИХТГ-ын захиалгаар Эрүүгийн хуулийн төсөл, Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн төслийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэрт хэвлэв.
- Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхэтгэл XIX, XX боть А4 хэмжээтэйгээр тус бүр 150 нийт 300 хувь хэвлэсэн.
- Захиргааны ерөнхий хууль А5 хэмжээтэйгээр 1000 хувь хэвлэсэн.
- Замын хөдөлгөөний аюулгүй байдал (эрх зүйн актын эмхэтгэл) А5 хэмжээтэйгээр 500 хувь хэвлэв.
- Хууль тогтоомжийн тухай хуулийг А5 хэмжээтэйгээр 500 хувь хэвлэв.
- Хүүхэд харах үйлчилгээий тухай хууль А6 хэмжээтэйгээр 500 хувь хэвлэв.
- Хамтын тэтгэвэрийн тухай хууль А6 хэмжээтэйгээр 1000 хувь хэвлэв.
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль А6 хэмжээтэйгээр 1000 хувь хэвлэв.

- Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга 2015 оны 12 дугаар сарын 3-ны өдөр батлагдсан. Тус хуулийг В5 хэмжээтэйгээр 1000 хувь хэвлэв.
- Зөрчлийн тухай хууль 2015 оны 12 дугаар сарын 4-ний өдөр батлагдсан. Тус хуулийг В5 хэмжээтэйгээр 1000 хувь хэвлэв.

ХЭВЛЭХ ҮЙЛДВЭРИЙН АЖИЛ

Тус байгууллагын хэвлэх үйлдвэр нь 2015 онд хэвлэх төлөвлөгөөт ажлаас гадна ХЗЯ-ны харьяа байгууллага болон гадны байгууллагын захиалгыг хүлээн авч гүйцэтгэж байна. Хэвлэх үйлдвэрт хэвлэж болох хамгийн том хэмжээ болох В3 форматад тохируулан ном болон бусад ажлын эх бэлтгэлийг хийж гүйцэтгэж байна.

2015 онд 80 нэр төрлийн **40.270** ширхэг ном, гарын авлага, тараах материал зэргийг үйлдвэрлэн тус байгууллагын нярав болон захиалагч байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Харъяа болон гадны байгууллагын 15 нэр төрлийн ажлыг гүйцэтгэж **21.480.000** төгрөгийн орлого оруулсан.

2015 оны эхний хагас жилийн байдлаар ХЗҮХ-ийн хэвлэх үйлдвэр хэвлэгдсэн ном, товхимол болон бусад хэвлэмэл бүтээгдэхүүний жагсаалт

№	ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ, ᠳᠣᠭᠠᠨᠠᠨᠢᠨᠠᠭ ᠳᠣᠭᠠᠨᠢᠨᠠᠭ, ᠳᠣᠭᠠᠨᠢᠨᠠᠭ ᠳᠣᠭᠠᠨᠢᠨᠠᠭ, ᠳᠣᠭᠠᠨᠢᠨᠠᠭ ᠳᠣᠭᠠᠨᠢᠨᠠᠭ	ᠣᠶᠠᠭᠡᠭᠡᠨᠢ			Хэвлэсэн ном
		ᠠᠵᠠᠭᠠ	ᠵᠢᠭᠡᠨ		
			ᠲᠠᠨᠢ	ᠣᠵᠤ	
1	Хууль зүйн мэдээлэл №34	625		625	I
2	Монгол улсын эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй ном	200		200	I
3	Хууль дээдлэх ёс сэтгүүл №04	310		310	I
4	Хуульчийн ёс зүй гарын авлага	500		500	I
5	Албан бланк	500		500	
6	Хууль зүйн мэдээлэл №35	625		625	II
7	Хууль зүйн мэдээлэл №36	625		625	II
8	Эрүүгийн хуулийн төсөл	200	200		II
9	Зөрчлийн тухай хуулийн төсөл	200	200		II
10	Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль, хүн худалдаалахын эсрэг	1000	1000		II
11	Хууль зүйн мэдээлэл №01	540		540	II
12	Хууль зүйн мэдээлэл №02	540		540	II
13	Хууль зүйн мэдээлэл №03	540		540	II
14	Хууль зүйн мэдээлэл №4	650		650	III
15	Хууль зүйн мэдээлэл №5	650		650	III
16	Хууль зүйн мэдээлэл №6	650		650	III
17	Хууль зүйн Англи хэлний орчуулгын гарын авлага	300		300	III
18	Монгол улсын Эрүүгийн хууль	500		500	III

19	Эрх зүйн туслалцааны төв бүртгэлийн дэвтэр	500	500		III
20	“Эгийн эх” ХХК танилцуулга	500	500		III
21	Хууль зүйн мэдээлэл №7,8	560		560	IV
22	Хууль зүйн мэдээлэл №9	560		560	IV
23	Хууль зүйн мэдээлэл №10	500		500	IV
24	Хууль дээдлэх ёс сэтгүүл №1	300		300	IV
25	Хууль зүйн мэдээлэл №11	500		500	IV
26	Хууль зүйн мэдээлэл №12	500		500	IV
27	МУ-ын иргэний хууль, ИХШХШТХ	500		500	IV
28	Хууль зүйн мэдээлэл №13	560		560	V
29	Монгол улсын үндсэн хууль /Өврийн/	1000		1000	V
30	Тахарын ерөнхий газар ЭЗББЭ	300	300		V
31	Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл /ХЗЯ/	200	200		V
32	ШШГТ тухай хуулийн төсөл /ХЗЯ/	200	200		V
33	Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл /УИХ-ын ТГ/	100	100		V
34	Посткоммунист орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага илтгэлийн эмхтгэл	100		100	V
35	МУ-ын хууль 22	100		100	V
36	НҮБ-ын хүүхдийн сан сургалтын гарын авлага	35	35		V
37	Хууль зүйн мэдээлэл №14	510		510	VI
38	Хууль зүйн мэдээлэл №15	510		510	VI
39	Хууль зүйн мэдээлэл №16	510		510	VI
40	Хөдөлмөрийн яам ЭЗББЭ	380	380		VI
41	Их засаг ОУИС-ийн хурлын эмхэтгэл	200	200		VI
42	Хууль дээдлэх ёс сэтгүүл №2	300		300	VI
43	Хууль зүйн мэдээ сонин	100		100	VI
44	Анкет	500	500		VI
45	Хууль зүйн мэдээлэл №17	510		510	VII
46	Хууль зүйн мэдээлэл №18	510		510	VII
47	Хууль зүйн мэдээлэл №19	510		510	VII
48	Хуульчийн сорилгийн хураамж	1500		1500	VII
49	Хууль зүйн мэдээлэл №20	510		510	VIII
50	Хууль зүйн мэдээлэл №21	510		510	VIII
51	Хууль зүйн мэдээлэл №22	510		510	VIII
52	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	200	200		
53	Хууль зүйн мэдээлэл №23	1060		1060	IX
54	Хууль зүйн мэдээлэл №24	460		460	IX
55	Хууль зүйн мэдээ сонин	1200		1200	IX
56	Плакат Хөдөлгөөнт цэг	1200		1200	IX
57	ХЗҮХ Танилцуулга	1000		1000	IX

58	Хууль сурталчлах брошур	1200		1200	IX
59	Хууль сурталчлах брошур	1200		1200	IX
60	Компьютерийн хаалт	800		800	IX
61	Хууль зүйн мэдээлэл №25	460		460	IX
62	Хууль зүйн мэдээлэл №26	460		460	IX
63	Хуулийн эзэнт гүрэн ном	800	700	100	IX
64	Хөдөлгөөнт цэг Плакат	600		600	X
65	МУ-ын хууль XIX боть	150		150	X
66	Хууль дээдлэх ёс сэтгүүл №03	300		300	X
67	Хууль зүйн мэдээлэл №27	460		460	X
68	Хууль зүйн мэдээлэл №28	460		460	X
69	Хууль зүйн мэдээлэл №29	460		460	X
70	ХЗҮХ дүрэм журмын эмхтгэл	80		80	XI
71	МУ-ын хууль XX боть	150		150	XI
72	Захиргааны ерөнхий хууль	1000		1000	XI
73	Хууль зүйн мэдээлэл №30	460		460	XI
74	Хууль зүйн мэдээлэл №31	460		460	XI
75	Хуулийн эзэнт гүрэн	150		150	XII
76	Монголын нотариатын танхим	300	300		XII
77	ХЗЯ хуулийн төсөл /ЗХХШТХ/	200	200		XII
78	Хууль зүйн мэдээлэл №32	420		420	XII
79	Хууль зүйн мэдээлэл №33	420		420	XII
80	Хууль зүйн мэдээлэл №34	420		420	XII
Æëëëëí ýõíýýñ °ññ°í ä¿íäýýð		40270	5715	34555	

Эх бэлтгэсэн ажил

1	Íñúí íýð	Àæëë ä¿éöýðäýñýí ääðääëäë	çàñâàð íðóóëñàí тоо	Öýíæýý	Í¿¿ðíëë òñí
1	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №34	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 óääà	A5	52
2	Монгол улсын эрх зүйн шинэтгэл ба харьцуулсан эрх зүй	Эх бэлтгэл Хавтас Монтаж	2 óääà	A5	116
3	Хууль дээдлэх ёс сэтгүүл №4	Эх бэлтгэл Монтаж	2 óääà	B5	74
4	Хуульчийн ёс зүй гарын авлага	Эх бэлтгэл Хавтас Монтаж	3 óääà	B5	90
5	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №35	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 óääà	A5	186
6	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл	Эх бэлтгэл Кальк	2 óääà	A5	80

	№36	хэвлэлт			
7	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №1	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	24
8	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №2	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	16
9	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №3	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	12
10	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №4	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	244
11	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №5	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	4
12	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №6	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	24
13	Хууль зүйн мэдээлэл эмхэтгэл №7,8	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	520
14	Эрүүгийн хуулийн төсөл	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	B5	114
15	Зөрчлийн тухай хуулийн төсөл	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	B5	308
16	Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	A6	36
17	English translation handbook-орчуулгын гарын авлага	Эх бэлтгэл Монтаж Хавтас	1 удаа	B5	264
18	Хууль зүйн туслалцааны төв бүртгэлийн дэвтэр	Эх бэлтгэл Хавтас	1 удаа	A4	120
19	Эрүүгийн хууль	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	342
20	“Эгийн эх” ХХК танилцуулга	Эх бэлтгэл Монтаж	1 удаа	A4	2
21	Хууль зүйн мэдээлэл №9	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	56
22	Хууль зүйн мэдээлэл №10	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	52
23	Хууль дээдлэх ёс сэтгүүл №1	Эх бэлтгэл Монтаж	2 удаа	B5	130
24	Хууль зүйн мэдээлэл №11	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	12
25	Хууль зүйн мэдээлэл №12	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0āāā	A5	
26	МУ-ын иргэний хууль, ИХШХШТХ	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	B5	416

27	Хууль зүйн мэдээлэл №13	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	32
28	Монгол улсын үндсэн хууль /Өврийн/	Монтаж,	2 удаа	A6	74
29	Тахарын ерөнхий газар ЭЗББЭ	Эх бэлтгэл Монтаж	2 удаа	A5	172
30	Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хуулийн төсөл /ХЗЯ/	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	B5	158
31	ШШГТ тухай хуулийн төсөл /ХЗЯ/	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	120
32	Посткоммунист орнуудын эрх зүйн хөгжлийн чиг хандлага илтгэлийн эмхтгэл	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	A5	172
33	МУ-ын хууль 22	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	A5	156
34	НҮБ-ын хүүхдийн сан сургалтын гарын авлага	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	A5	160
35	Хууль зүйн мэдээлэл №14	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	152
36	Хууль зүйн мэдээлэл №15	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	104
37	Хууль зүйн мэдээлэл №16	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	64
38	Хөдөлмөрийн яам ЭЗББЭ	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 0᠗᠗᠗	A5	388
39	Хууль дээдлэх ёс сэтгүүл №2	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	114
40	Хууль зүйн мэдээлэл №17	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	28
41	Хууль зүйн мэдээлэл №18	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	20
42	Хууль зүйн мэдээлэл №19	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	28
43	Хуульчийн сорилгийн хураамж	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	708
44	Хууль зүйн мэдээлэл №20	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	28
45	Хууль зүйн мэдээлэл №21	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	20
46	Хууль зүйн мэдээлэл №22	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	24
47	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	150
48	Хууль зүйн мэдээлэл №23	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0᠗᠗᠗	A5	24

49	Хууль зүйн мэдээлэл №24	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	80
50	Хууль зүйн мэдээлэл №25	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	32
51	Хууль зүйн мэдээлэл №26	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	36
52	Хуулийн эзэнт гүрэн ном	Эх бэлтгэл Монтаж Хавтас	2 удаа	B5	380
53	Хууль сурталчлах ажлын Плакат	Эх бэлтгэл	1 удаа	A3	1
54	МУ-ын хууль XIX боть	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	A4	512
55	Хууль дээдлэх ёс сэтгүүл №03	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	120
56	Хууль зүйн мэдээлэл №27	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	28
57	Хууль зүйн мэдээлэл №28	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	16
58	Хууль зүйн мэдээлэл №29	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	28
59	ХЗҮХ дүрэм журмын эмхтгэл	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	372
60	МУ-ын хууль XX боть	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	A4	476
61	Захиргааны ерөнхий хууль	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	A5	48
62	Хууль зүйн мэдээлэл №30	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	12
63	Хууль зүйн мэдээлэл №31	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	88
64	Монголын нотариатын танхим	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	128
65	ХЗЯ хуулийн төсөл /ЗХХШТХ/	Эх бэлтгэл Монтаж, Хавтас	2 удаа	B5	70
66	Хууль зүйн мэдээлэл №32	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	42
67	Хууль зүйн мэдээлэл №33	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	54
68	Хууль зүйн мэдээлэл №34	Эх бэлтгэл Кальк хэвлэлт	2 0000	A5	-

--oOo--

АЖИЛТНУУДЫН АЖЛЫН АМЖИЛТ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨДӨЛГӨӨН

1. Эрхлэгч: А.Түвшинтулга /Э.Өнөрбаяр 2015 оны 5 сар хүртэл/
2. Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Г.Билгүүн

3. Эрх зүйн мэдээллийн компьютерийн мэргэжилтэн Т.Галбадрах
4. Эрх зүйн мэдээллийн мэргэжилтэн М.Уянга
5. Эрх зүйн мэдээллийн мэргэжилтэн Да.Мөнхжаргал
6. Сургалт хариуцсан мэргэжилтэн Д.Цэцэгдарь
7. Хэвлэх үйлдвэрийн менежер Л.Гүрдорж
8. Эх бэлтгэгч, дизайнер До.Мөнхжаргал
9. Офсет машин хэвлэгч Д.Аранжамба
10. Офсет машин хэвлэгч Н.Батнасан
11. Дэвтэрлэгч М.Баярмаа

Хүний нөөцийн шилжилт хөдөлгөөн

2015 оны 3 дугаар сард яамны бодлого шийдвэрийн дагуу Хууль тогтоомж сурталчлах албаны менежер Г.Сарангэрэл, Э.Энхчимэг, дэвтэрлэгч О.Хишигмаа нар орон тооны цомхотголд орж чөлөөлөгдсөн. Эх бэлтгэгч Б.Цэрэнлхам, Офсет машины хэвлэгч Н.Батнасан нар өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн тул зохих журмын дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр зар явуулж Д.Мөнхжаргал, Б.Нувааншарав нарыг ажилд шалгаруулж авсан.

Ажлын амжилт, шагнал урамшуулал

2015 онд тус нэгжийн ажилтнуудын ажил хөдөлмөрийг үнэлэж дараах шагналаар шагнасан болно. Үүнд:

- “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдэгээр Эрхлэгч А.Түвшинтулга
- “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан” тэмдэгээр Эрх зүйн сургалт сурталчилгааны мэргэжилтэн Г.Билгүүн
- Хууль зүйн яамны “Хүндэт жуух”, “Хөдөлмөрийн салбарын тэргүүний ажилтан” тэмдгээр Эрх зүйн мэдээллийн мэргэжилтэн М.Уянга
- Хөнгөн үйлдвэрийн “80 жил” тэмдгээр Хэвлэх үйлдвэрийн менежер Л.Гүрдорж
- “Хэвлэлийн тэргүүний ажилтан” тэмдэгээр Офсет машины хэвлэгч Д.Аранжамба нар тус тус шагнуулсан.
-

ДҮГНЭЛТ

(ТАЙЛАНТ ХУГАЦААНД ХИЙСЭН АЖЛЫН ҮР ДҮН, БИЕЛЭЛТ)

Тайлант хугацаанд Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Хууль зүйн салбарын нээлттэй бодлого, төлөвлөгөөний хүрээнд болон тухайлан, Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө /ХЗЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын баталсан/, ХЗҮХ-ийн 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөө зэрэгт тусгагдсан ажлыг хэрэгжүүлж ажиллаа.

Эдгээрээс Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр 2015 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд туссан, тус нэгжийн үйл ажиллагаанд хамааралтай нийт **11** ажлыг зохих түвшинд гүйцэтгэж ажилласан байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2015 оны үйл ажиллагааны Төлөвлөгөөнд нийт 21 багц ажил хийхээр төлөвлөснөөс 20 багц ажлыг төлөвлөгөөнд заасны дагуу бүрэн хийсэн. Нэмэлтээр нэг багц ажил буюу “дотоод сургалт зохион байгуулах” ажлыг нэмэлтээр хариуцан хийсэн. Харин нэг төрлийн ажил үүнд: 23.5.ЭЗМНСанг интернетгүй үед хэрэглэх хувилбар буюу DVD-нд буулгах эл ажлыг Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг CD хувилбарыг худалдаанд гаргах ажлын бэлтгэл ажлыг хийсэн. Гэвч үндсэн кодыг CD-нд хуулсанаар

хамгаалах боломж багасаж алдагдах эрсдэл үүсэхээр байгаа тул энэ ажлыг хийх шаардлаггүй гэж үзсэн болно.

Эдгээрээс дүгнэвэл нийт төлөвлөгөөт ажлын биелэлт 95.2 хувьтай биелэж, 1 төрлийн ажил нэгжийн үйл ажиллагаанаас үл хамаарах тодорхой шалтгаанаар хийгдэх боломжгүй болсон болно.

Товчилсон үгийн тайлал

ХЗҮХ-Хууль зүйн үндэсний хүрээлэн

ХЗЯ-Хууль зүйн яам

БСШЯ-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам

БХЗГ-Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар

ГХЯ-Гадаад хэргийн яам

ЗГХЭГ-Засгийн газрын Хэрэг эрхлэх газар

ЗТЯ-Зам, тээврийн яам

ЕБС-Ерөнхий боловсролын сургууль

НҮБ-Нэгдсэн үндэстний байгууллага

НЗДТГ-Нийслэлийн Засаг даргын тамгын газар

МУ-Монгол Улс

ШШГТ хууль-Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль

ИХШХШТХ-Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль

СЯ-Сангийн яам

ТББ-Төрийн бус байгууллага

ТӨҮГ-Төрийн өмчит үйлдвэрийн газар

ХБНГУ-Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

ХХК-Хязгаарлагдмал хариуцлагатай компани

ХХАЯ-Хүнс, хөдөө, аж ахуйн яам

---ooOoo---

**ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН 2015 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН
АЖЛЫН ТАЙЛАН**

2015.12.25.

Захиргааны хэлтэс нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бодлого төлөвлөлт, түүний хэрэгжилтийг зохион байгуулж, хүний нөөц, санхүү, аж ахуй, дотоод дэг журам, архив бичиг хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, байгууллагын өдөр тутмын үйл ажиллагаа болон салбар нэгжүүдийн үйл ажиллагааны уялдаа холбоог ханган хүрээлэнгийн захиралд мэдээлэл өгч ажилласан болно. 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд болон бусад ажлын хүрээнд хийгдсэн ажлыг 2015 оны жилийн эцсийн байдлаар тайланд тусгалаа.

Хүний нөөц:

- 2015 оны хүний нөөцийн бүрэлдэхүүн, шилжилт хөдөлгөөн

Хууль зүйн сайдын 2015 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн “Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрэм, зохион байгуулалтын бүтэц, орон тоог батлах тухай” А/44 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсантай холбогдуулан Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн Б-13 дугаар тушаалаар ажилтныг ажлаас чөлөөлж, ажилтныг томилох тухай тушаал батлагдсан ба 2015 оны 12 сарын 25-ны өдрийн байдлаар нийт 32 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Нийт албан хаагчидтай Хөдөлмөрийн гэрээг шинэчлэн байгуулсан.

Хүрээлэнгийн бүтэц, орон тоо өөрчлөгдсөнтэй холбоотойгоор Хууль зүйн судалгааны төвийн ажиллах журам /2015.04.13-ны өдрийн А/03 тушаалын нэгдүгээр хавсралтаар/, Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн журам /2015.10.07-ны өдрийн А/16 тушаалаар/, Номын сангийн ажиллах журам /2015.04.13-ны өдрийн А/03 тушаалын хоёрдугаар хавсралтаар/, “Хөдөлмөрийн дотоод журам”-ыг 2015 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн А/04 тушаалаар, “Хууль дээдлэх ёс” сэтгүүлийн журмыг 2015 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А-05 тоот тушаалаар тус тус шинэчлэн батлуулсан.

Мөн “Ажлын байрны тодорхойлолт”-ыг шинэчлэн боловсруулж ХЗҮХ-ийн захирлын 2015 оны 3 дугаар сарын 04-ний өдрийн Б-14 дүгээр тушаалаар батлуулав.

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хөдөлмөрийн дотоод журмын 7.11-д заасны дагуу нийт ажилчдаас санал авч 2015 оны ээлжийн амралтын хуваарийг ажлын зохион байгуулалтыг харгалзан үзэж боловсруулж батлуулсан.

Мөн “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр” /2015-2017он/-ийг хүрээлэнгийн захирлын 2015 оны 6 дугаар сарын 02-ны өдрийн А-07 тоот тушаалаар, “Албан хаагчийн ёс зүйн дүрэм 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/17 тушаалаар баталсан.

Тус хүрээлэнгийн албан хаагчдын хувийн хэргийн бүрдүүлбэрийг журмын дагуу бүрдүүлсэн. Нийт 32 ажилтны байгууллагын үнэмлэхийг шинэчлэн хэвлүүлж олгосон.

“Хүний нөөцийн бодлогын баримт бичиг”-ийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн А/18 тушаалаар батлуулсан, уг баримт бичгийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг гаргав.

Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйл, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн

хөдөлмөрийн дотоод журмын 7.11-д заасны дагуу нийт ажилтнуудын саналын дагуу ээлжийн амралтын хуваарийг ажлын зохион байгуулалтыг харгалзан боловсруулж батлуулсан.

Хүний нөөцийн чиглэлээр /А-01-24/, /Б-01-106/ нийт 130 тушаалын төсөл боловсруулж тушаал батлуулсан.

Энэ хугацаанд 1 ажилтан ажилд эгүүлэн томилогдсон, 5 ажилтан шинээр ажилд томилогдох тушаал гарсан.

- Базаррагчаа овогтой Гончигсумлааг 2015 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Бодлогын судлаачаар томилох.
- Эрдэнэбат овогтой Уянгыг 2015 оны 5 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн Хууль зүйн судалгааны төвийн бодлогын судлаачаар томилох
- Жигмэддорж овогтой Ариунцэцэгийг 2015 оны 8 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн Хууль зүйн судалгааны төвийн бодлогын судлаачаар томилох,
- Владиймор овогтой Мөнхгэрэлийг тус хүрээлэнгийн үйлчлэгчээр 2015 оны 9 дүгээр сарын 08-ны өдрөөс томилох,
- Цэвээн овогтой Одгэрэлийг 2015 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Хууль зүйн судалгааны төвийн бодлогын судлаачаар томилох,
- Жирэмсний болон амаржсаны амралттай байсан тогтмол Хууль зүйн судалгааны төвийн Бодлогын судлаач Банзрагч овогтой Ундрахыг 2015 оны 9 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн өөрийнх нь хүсэлтээр ажилд нь эгүүлэн томилох зэрэг болно.

Нийт 7 ажилтан өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдсөн.

Жирэмсний болон амаржсаны амралттай болон хүүхэд асрах чөлөөтэй ажилтан 4 байна.

- Бодлогын судлаач С.Бүжинлхам
- Сургалт хариуцсан менежер Д.Оюун-Эрдэнэ
- Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Д.Майцэцэг
- Эрх зүйн мэдээллийн мэргэжилтэн Б.Хулан нар болно.

Захиргааны зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу эрхэлсэн ажилдаа үр бүтээлтэй, тогтвор суурьшилтай ажилласан ажилтнуудыг Төрийн одон медаль, Хууль зүйн яамны болон бусад яамд, мэргэжлийн холбоодын шагналд шагнуулахаар тодорхойлон, ажил байдлын тодорхойлолт, холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлэн албан бичгийн хамт хүргүүлсэн.

Хууль зүйн яамны сайдын 2015 оны 6 сарын дугаар 18-ны өдрийн А/130 тоот тушаалаар Хууль зүйн мэдээлэл, сургалт, сурталчилгааны төвийн эрхлэгч А.Түвшинтулга, Судалгааны төвийн Бодлогын ахлах судлаач Б.Энх-Амгалан, Бодлогын судлаач Б.Одонгэрэл нар “Хууль зүйн албаны тэргүүний ажилтан” тэмдэг, БСШУЯ-ны “Жуух бичиг”-ээр Номын сангийн менежер, судлаач Х.Ариунсүрэн, Бодлогын судлаач Э.Уянга, Эрх зүйн мэдээллийн мэргэжилтэн М.Уянга, бодлогын судлаач Ц.Одгэрэл нар ХЗЯ-ны “Хүндэт жуух” бичгээр, ХАНХЯ-ны Жуух бичгээр түүнчлэн бусад мэргэжлийн холбоодын шагналаар Эрх зүйн сургалт, сурталчилгаа хариуцсан мэргэжилтэн Г.Билгүүн “Хэвлэл мэдээллийн тэргүүний ажилтан”, Хэвлэх үйлдвэрийн менежер Л.Гүрдорж Хөнгөн үйлдвэрийн 80 жилийн ойн медаль, Хэвлэх үйлдвэрийн офсет машины хэвлэгч Д.Аранжамба “Хэвлэлийн тэргүүний ажилтан” цол, тэмдгээр тус тус шагнагдав.

Дотоод дэг журам, ажлын цаг ашиглалт

Ажлын цаг ашиглалтыг сайжруулах болон “Хөдөлмөрийн дотоод журам” шинэчлэн батлагдсантай холбогдуулан нийт албан хаагчдын хурал хийж, журмын өөрчлөлтийн талаар танилцуулга яриа хийсэн.

Ажлын цаг ашиглалт болон ажилдаа алдаа дутагдал гаргасан ажилтнуудад “Хөдөлмөрийн дотоод журам”, Хөдөлмөрийн тухай хуулийн хүрээнд 6 ажилтанд сануулах болон цалингийн тодорхой хувийг бууруулах сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авсан байна.

Ажилтнуудын цагийн бүртгэл, ирцийн мэдээг цаг бүртгэлийн системээс гаргаж Захиргааны зөвлөлд танилцуулсан.

Төлөвлөгөө, тайлан, бусад үйл ажиллагаа:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2014 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг 2015 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн 02/44, 2015 оны эхний хагас жилийн хяналт шинжилгээ, үнэлгээний тайланг 2015 оны 06 сарын 05-ны өдөр 01/175 тоот албан бичгээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Хяналт шинжилгээ, үнэлгээний гүйцэтгэл сайжруулах төлөвлөгөө, 2015 оны эхний хагас жилийн Хяналт шинжилгээ, үнэлгээний тайлан, Сайдын шуурхай хурлын үүрэг даалгаврын биелэлт, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Цахим засаг Үндэсний хөтөлбөр /2012-2016/, Өсвөр үе, залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр /2007-2015/ “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдээлэл, сурталчилгааны хөтөлбөр”, “Жендэрийн тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр”, “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үндэсний хөтөлбөр”, “Хүн худалдах, ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах хөтөлбөр”-үүдийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2015 оны 05 сарын 20-ны өдрийн 01/155, төлөвлөгөөний биелэлтийг 2015 оны 09 сарын 29-ний өдрийн 01/293 тоот албан бичгээр Хууль зүйн яаманд хүргүүлсэн.

Хууль зүйн сайдын шуурхай хурлаас өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийг 2015 оны 6 сарын 08-ны өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2015.06.18-ны өдрийн 01/194, 2015 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2015. 09.04.-ний өдрийн 01/260, 2015 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2015.10.13-ны 01/321, 2015 оны 11 дүгээр сарын 09-ны өдрийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг 2015.11.25-ны 01/361 албан бичгээр цаг тухайд нь гарган хүргүүлсэн.

ХЗҮХ-ийн захирлын 2015 оны үр дүнгийн гэрээний биелэлт / гэрээний хавсралт 2015 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт /, 2015 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн Хууль зүйн сайдын албан даалгаврын биелэлтийг тус тус 2015 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 01/402, 01/403 албан бичгээр хүргүүлэв.

Мөн ХЗҮХ-ийн захирлын 2016 оны үр дүнгийн гэрээний төсөл / гэрээний хавсралт 2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөө /-ийг 2015 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 01/411 албан бичгээр хүргүүлсэн.

Салбарын статистик мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх, ашиглах журмын дагуу хавсралт ёсоор 2015 оны 4- 11 дүгээр саруудын статистик мэдээллийг 02/41, 01/64, 01/110, 01/141, 01/172, 01/208, 01/224, 01/300, 01/352, 01/374 тоот албан бичгээр хугацаанд нь Хууль зүйн яаманд хүргүүлэв.

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн талаар 7 хоног бүрийн Даваа гарагийн захиргааны зөвлөлийн хурал болон шуурхай хуралд тогтмол оролцож хурлын тэмдэглэлийг хөтөлсөн. Өгсөн үүрэг даалгаврын танилцуулж, биелэлтэд хяналт тавьж ажилласан.

Архив, албан хэрэг хөтлөлтийн хүрээнд:

Ирсэн, явсан албан бичгийг хөтлөх, удирдах ажилтанд танилцуулах, удирдлагаас өгсөн зааврын дагуу холбогдох ажилтанд хүргэх, бүртгэл хяналтын карт хөтлөх, явуулах баримт бичигт дугаар олгох, шуудангаар явуулах зэрэг бичиг хэргийн урсгалын хэвийн үйл ажиллагааг ханган ажилласан.

Хугацаатай албан бичгийн шийдвэрлэлтийн байдалд хяналт тавин, холбогдох нэгжийн удирдлагад тухай бүр нь танилцуулж, удирдлагад мэдээлэл өгч ажилласан.

Энэ хугацаанд хүрээлэнгээс нийт 416 албан бичиг явсан, 342 албан бичиг гадны байгууллагаас ирсэн. Хууль зүйн яаманд хүргэх албан бичгийг биечлэн хүргэсэн ба бусад шуудангаар 43 албан бичгийг хүргүүлсэн байна.

Хугацаа хэтэрсэн албан бичиг байхгүй болно.

Нийт ирсэн албан бичгээс 132 албан бичигт хариу явуулсан. Мөн 4 албан бичигт хүсэлтийн дагуу имэйл-ээр, утсаар буюу амаар хариу өгсөн 6 байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2015 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн А/09 дүгээр тушаалаар байгуулсан “Архив албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт”-ын улсын үзлэгт бэлтгэх ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн хурлыг 2 удаа зохион байгуулж хурлын тэмдэглэлийг хөтөлсөн.

Баримт бичиг нягтлан шалгах комиссыг шинэчлэн байгуулж, комиссын хурлыг 3 удаа хуралдуулсан.

Нэгжүүдээс архивт шилжүүлээгүй байсан баримт материалыг хүлээн авч үдэж хавтаслан хадгаламжийн нэгж болгох, хадгалах тэдгээрийг бүрэн бүтэн хэвийн байлгах хангах, архивт хадгалж байгаа хэрэг, хадгаламжийн нэгжийн данс, бүртгэл жагсаалтыг нягтлан шалган нэмж хөтлөх зэргийг ажлууд хийгдсэн.

Улсын үзлэгийн 4 үндсэн чиглэлийн дагуу бэлтгэл ажлын хүрээнд улсын үзлэгт бэлтгэх төлөвлөгөө гаргаж, нийт ажилтнуудад Нийслэлийн архивын газрын холбогдох мэргэжилтнээр Архив, албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулахад оролцсон.

Улсын үзлэгийн төлөвлөгөөний биелэлтийг гарган удирдлагад танилцуулсан. Тус үзлэгээр Хууль зүйн үндэсний хүрээлэн нь “А” буюу 93,1 үнэлгээ авсан байна. Төлөвлөгөө болон төлөвлөгөөний биелэлтийг хавсаргав.

Өргөдөл, гомдол:

Энэ хугацаанд нийт 38 өргөдөл ирсэн. Үүнээс:

- Ажлаас чөлөөлөгдөх хүсэлт 8,
- Ажилд орох 6,
- Чөлөө хүссэн 10,
- Тэтгэмж хүссэн 2,
- Бусад 16 өргөдөл ирсэн.

Өргөдлийн дагуу захирлын тушаал 24 гарсан. Шийдвэрлэгдээгүй 1 /иргэн Э.Сэлэнгийн сургалтын төлбөрийн талаар/ өргөдөл байна, бөгөөд бусад өргөдөл, гомдлыг цаг тухайд нь шийдвэрлэсэн байна.

Байгууллагын мэдээллийн технологи, аюулгүй ажиллагаа

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2015 оны төлөвлөгөөний хүрээнд:

Зорилт 26.1. Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудаст ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх

Шилэн дансны тухай хууль батлагдаж 2015 оны 01-р сарын 01-ээс мөрдөж эхэлсэнтэй холбогдуулан Засгийн газрын шилэн дансны портал сайтад байгууллагын төсөв, хөрөнгөтэй холбоотой дараах мэдээллүүдийг оруулав. Үүнд:

ТӨСӨВ ГҮЙЦЭТГЭЛ

- Гүйцэтгэлийн kpi
- Төсөв ба гүйцэтгэл
- Төсвийн зарлагын хэмнэлт
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ

ТЕНДЕР, ХУДАЛДАН АВАЛТ

- Тендерийн шалгаруулалт
- Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт

БАЙГУУЛЛАГА

- Хандив, тусламжын хэмжээ, түүний зарцуулалт
- Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн жагсаалт
- Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч буй эрх бүхий этгээдийн жагсаалт

Дээрх мэдээллүүдийг сар бүрийн 8-ны дотор 2015 оны 1-11-р сар хүртэл Шилэн дансны порталд өссөн дүнгээр оруулсан ба маягтаар сайтад мэдээ хэлбэрээр оруулсан.

Нийт тоон мэдээлэл:

Сайтад тавигдсан нийт мэдээлэл	26
Гүйцэтгэлийн kpi	1
Төсөв ба гүйцэтгэл	11
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ	1
Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалт	
Байгууллагын өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрийн жагсаалт	5
Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч буй эрх бүхий этгээдийн жагсаалт	8

Зорилт 28.1. Байгууллагын цахим хуудсыг технологийн хувьд цаг алдалгүй хөгжүүлэх, удирдлагын шаардлагад нийцсэн модуль, програмчлалыг тухай бүр хийж гүйцэтгэх, хураангуй англи хувилбарыг ажиллагаанд оруулах

ХЗҮХ-ийн цахим хуудаст Хууль зүйн мэдээ сонинг цахим хувилбарын 33 дугаарыг холбосон. Үйл явдалтай холбоотой зарлал, мэдээллийг тогтмол оруулж байгаа бөгөөд зарим хариуцсан ажилтан мэдэгдээгүйн улмаас мэдээлэл хоцорсон тохиолдол цөөнгүй.

Байгууллагын дүрэм, Хууль дээдлэх ёс сэтгүүлийн журам шинэчлэн батлагдаж, бүтэц орон тоо өөрчлөгдсөн тул цахим хуудас дахь танилцуулга мэдээллүүдийг нэг бүрчлэн шинэчлэв. Мөн шинээр гарсан ном товхимлын талаар нийтэд мэдээллэх үүднээс нүүр хуудаст шинэ номын булан нээсэн.

Мэдээ, мэдээллийг шууд гарчигар нь жиргэх, фэйсбүүкээр шэйрлэх боломжуудыг нэмсэн. Хамгаалалтыг сайжруулах үүднээс нэвтрэх эрхийн түлхүүрийг 8 удаа шинэчилж, мөн скриптүүд дээр тохиргоо хийсэн. Скриптийн кодлол хуучирснаас facebook робот сайтыг бүрэн хэрэх боломжгүйгээс үүдэн facebook share товч програмчлалын дагуу үйлдэл гүйцэтгэж чадахгүй байна. Иймд цахим хуудсыг технологийн хувьд шинэчлэх шаардлагатай.

Цахим хуудсыг модулийн болон агуулгын хувьд дахин зохион байгуулж, мэдээллийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтэд нийцүүлж өөрчлөв.

Зорилт 29.1. ХЗҮХ-ийн нийт ажилтнуудын компьютерийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх

Эх хавтангийн гэмтэл 1, файл устгасан 1, вирус 43, үйлдлийн системийн 33, хэрэглээний програмын тодорхой тооны доголдол гарч тухай бүр засвар үйлчилгээг хийж гүйцэтгэсэн. Сүлжээний төв свичийн доголдолыг тухай бүр засч хэвийн ажиллуулсан. Компьютерийн гэмтэл техник хангамжийн хувьд бага, програм хангамжийн хувьд ихээр гарч байгаа нь компьютерийн зүй бус хэрэглээтэй холбоотой байна.

Байгууллагад ашиглагдаж буй компьютерууд нь хэрэглээнд нэвтрээд 5 жил болж байгаа бөгөөд хэрэглээний элэгдэл болон технологийн хоцрогдолд орсон байна. Иймд компьютеруудыг 4-р үеийн Core i7 CPU үзүүлэлт бүхий компютераар шинэчлэх шаардлагатай.

Захирлаас өгсөн үүрэг даалгаврын хүрээнд:

1. Хуульчийн шалгалтын бүртгэлийн системийг бэлэн болгох шаардагдах зардлыг гаргах

Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах, ХЗЯ-нд мэдээлэл хүргэх үүднээс үйл ажиллагааны болон санхүүгийн танилцуулга боловсруулсан. Арилжааны банкуудтай байгуулсан гэрээнүүдийг дүгнэж гэрээ дуусгавар болсон банкны үйлчилгээнүүдийг сэргээж, Хаан банк болон бусад банкуудтай гэрээг шинэчилж хийсэн. Мөн шалгалтын ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргахад оролцсон.

2. Хуульчийн шалгалтын системийг хэвийн ажиллуулах

Хуульчийн мэргэжлийн шалгалтыг системийн талаас хэвийн ажиллуулахад шаардагдах бүхий л арга хэмжээг авч ажиллав. Тухайлбал, систем ачаалал даахгүй унахаас сэргийлж үзүүлэлтийг өндөрсгөх, шалгалтын үеэр мөрдөх журмын хэрэгжилтийн дагуу техникийн арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагаа хэрэгжүүлсэн.

3. Хуульчийн мэргэжлийн шалгалтын зохион байгуулалтад оролцох

Хуульчийн мэргэжлийн шалгалтын мэдээллийн технологийн хэсгийг хариуцан ажилласан. Хуульчийн шалгалтын системийг хэвийн найдвартай ажиллагааг хангах, гэнэтийн техникийн асуудлын үед авч хэрэгжүүлэх дараах арга хэмжээг авсан. Үүнд:

- Шалгалтын системийг шинэчлэн сайжруулах
- Шалгалтын системийг тестлэх
- Серверийн хүчин чадлыг тооцоолох
- Серверийн хүчин чадлыг нэмэгдүүлэх
- Шалгалтын системийн техникийн уналтын үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг томъёолох
- Шалгалтын системийн бааз, скриптүүдийг нөөцөлж архивлах
- Шалгалтын дүн мэдээг нэгтгэх, тайлагнах

Мөн шалгалтыг зохион байгуулах танхим, сүлжээний урсгалын дэд бүтцийг тооцох, нэмэлт танхим бэлтгэх зэрэг үйл ажиллагаанд оролцсон.

4. Архивын улсын үзлэгт бэлтгэх, үнэлүүлэх

Монгол Улсын Хууль зүйн сайдын 2015 оны 06 дугаар сарын 24-ны өдөр баталсан архив, албан хэрэг хөтлөлт, төрийн байгууллагын ажлын зохион байгуулалтын улсын үзлэгийн удирдамж хуваарь, дүгнэх үзүүлэлт, аргачлалын дагуу байгууллагын цахим архивыг цэгцлэх, мэдээллийн технологийн дэд бүтэцийг зураглах, цахим хуудасны агуулгыг шинэчлэх, шилэн дансны мэдээлэл шинэчлэх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Улсын үзлэгийн комисс 4 үндсэн үзүүлэлтээр архивын улсын үзлэгийг явуулсан бөгөөд төрийн байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлж буй байдал гэсэн хэсэгт Хууль зүйн үндэсний хүрээлэн 96 хувийн үнэлгээ авсан байна.

5. Сургалтын танхимын хуанли хөтлөх

Google Calendar-ыг ашиглан сургалтын танхимын түрээсийн хуанлийг тогтмол хөтөлж байгаа бөгөөд энд оруулснаар удирдлага болон холбогдох хүмүүс хаана ч, хэзээ ч танхимын хуваарийг харах боломжтой болсон.

2015 онд нийт 324 үйл явдлыг танхим, цаг, нэртэй нь оруулсан байна. Бүртгэл хөтлөлтийн талаарх үзүүлэлтүүдийг графикаар үзүүлэв.

- 7 хоногийн өдөр бүрийн бүртгэл


Танхимын түрээс

Selected resource: Танхимын түрээс
Selected time range: 12/31/2014 - 12/13/2015

Utilization: 19%


8hrs/day or more = 100% utilization. Weekends are omitted.

Booking per day of week




- Өдөр бүрийн бүртгэл

Booking per days



- Бүртгэлийн дундаж интервал



6. ХЗҮХ-ийн 2015 оны төлөвлөгөөг хэвлэмэл самбар байдлаар хийх

Удирдлага болон нэгж тус бүрээр ХЗҮХ-ийн 2015 оны төлөвлөгөөг цаасан хэлбэрээр гаргахад тохиромжтой хуанли боловсруулан хэвлүүлж, захирал, эрхлэгч нарт хүлээлгэн өгөв.

7. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн шинэ загвар санал болгох

Орчин үеийн болон өнгө хийцийн хувьд шинэчилж болохуйц дизайны зураглал хийж танилцуулав.

8. Эд хөрөнгийн тооллогын комисст тоног төхөөрөмжийн тооллого хийх

ХЗҮХ-ийн захирлын тушаалаар эд хөрөнгийн тооллогын комисст орж тоног төхөөрөмжийн тооллого хийв. Тооллогын явцад ажилтнуудын шилжих хөдөлгөөнөөр агуулахад хураагдсан компьютер, принтер бусад тоног төхөөрөмжийг дахин тоолж, нягтлав.

Тоног төхөөрөмжүүдээс элэгдлийн хугацаа дууссан, дахин засвар авахгүйгээр эвдэрсэн, байнгын доголдолтой буюу урсгал засвар шаардсан компьютер, зөөврийн компьютер, хэвлэгч, хувилагч, сканнер, тог баригч болон бусад тоног төхөөрөмж, төмрийн үйлдвэрийн багаж, техник хэрэгслийг актлах санал гаргасан. Эдгээр тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын хугацаа хэтэрсний улмаас засч сэлбэх сэлбэг нь зах зээл дээр нийлүүлэгдэхээ больсон өөрөөр хэлбэл дахин засч ашиглах боломжгүй. Нийт 91 нэр төрлийн 141,920,136 төгрөгийн тоног төхөөрөмж актлах шаардлагатай байгааг тооллогын комисст болон өмч хамгаалах зөвлөлд илтгэсэн.

9. Төрийн албаны зөвлөлийн бүрэлдэхүүн хөдөлгөөний бүртгэл хөтлөх, цалин хөлсний мэдээлэл оруулах

Жил бүрийн эцэст төрийн албаны зөвлөлийн бүртгэлийн програмд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг шинэчилж, цалингийн мэдээллийг оруулан ХЗЯ болон ТАЗ рүү илгээдэг. Энэ онд шинэчлэгдсэн мэдээллийн тоон үзүүлэлтийг дор үзүүлэв.

Мэдээлэл	Тоо
Ажлаас чөлөөлөгдсөн болон халагдсан албан хаагчдын тоо	33
ТАХ-ын хөдөлгөөн, томилгооны судалгаа	2
Шинээр оруулсан анкет	5
Цалингийн тайлан байгууллагын албан хаагчаар	58

**2015 ОНЫ 12 ДУГААР САРЫН 25 БАЙДЛААРХИ
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Хууль зүйн сайдын 2015 оны 3 дугаар сарын 02-ны өдрийн А/44 дугаар тушаалын хавсралтаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн орон тоо, албан тушаалын ангилал зэрэглэлийг нийт 33 хүний бүрэлдэхүүнтэйгээр баталсан. Одоогоор 32 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

I. Санхүүжилт

2015 онд Улсын төсвийн тодотголоор улсын төсвийн санхүүжилтаас 399,434,700.0 сая төгрөг, . Үндсэн үйл ажиллагааны (ном борлуулалтын орлого, заалны түрээс, номын сангийн үйлчилгээ, сурталчилгаа) зэрэг орлогоос 120,000.000.0 сая төгрөг нийт 519.434.700.0 төгрөгийн төсөв батлуулсан.

Орлогын төрөл /хугацаа/	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт.хэтрэлт	хувь
Төсвийн урсгал санхүүжилт	399,434,700.0	397,638,200.0	1,796,500.0	
Нийт орлого	399,434,700.0	397,638,200.0	1,796,500.0	

2015 оны үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө

Д/д	Орлогын төрөл	Нийт дүн	Гүйцэтгэл	Зөрүү
1	Ном борлуулалтын орлого	33,349,241.00	48,358,367.00	(15,009,126.00)
2	Сэтгүүл борлуулалтын орлого	28,445,400.00	38,837,763.00	(10,392,363.00)
3	Заалны түрээсийн орлого	9,000,000.00	14,885,000.00	(5,885,000.00)
4	Номын сангийн үйлчилгээний орлого	4,468,500.00	2,127,500.00	2,341,000.00
5	Видео шторк, лед дэлгэцийн орлого	12,000,000.00	3,750,000.00	8,250,000.00
6	Байрны түрээс	27,000,000.00	32,470,000.00	(5,470,000.00)
7	Төлбөртэй сургалт з/б орлого	6,000,000.00	24,389,500.00	(18,389,500.00)
	Нийт дүн	120,263,141.00	164,818,130.00	(44,554,989.00)

II. Зардал

Үйл ажиллагааны зардлын төсөв 519,434,700.0 төгрөг бөгөөд 12 дугаар сарын 25--нийг дуустал 493,295,720.0 төгрөгийн зардал гаргасан нь төсвийн зарлагын зарцуулалт 94,9 хувьтай байна.. Сангийн сайдын 2010 оны 3 дугаар сарын 9-ний өдрийн 48 дугаар тушаалын 5 дугаар зүйлд заасны дагуу зардлын бүлгийн дүнгээс хэтрүүлсэн зардал байхгүй болно.

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Хугацаа: 15.12.25

SORT_ID	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
1	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	519,434,700.00	493,295,720.00	26,138,980.00	94.97
2	II. НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	519,434,700.00	493,295,720.00	26,138,980.00	94.97
3	IV. УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	519,434,700.00	493,295,720.00	26,138,980.00	94.97
4	Бараа, үйлчилгээний зардал	470,645,700.00	447,866,820.00	22,778,880.00	95.16
5	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	325,902,400.00	325,902,400.00	-	100.00
6	Үндсэн цалин	260,665,200.00	253,319,638.00	7,345,562.00	97.18
7	Нэмэгдэл цалин	44,667,700.00	54,045,850.00	(9,378,150.00)	121.00
8	Унаа, болон бусад нөхөн олговор	20,569,500.00	18,536,912.00	2,032,588.00	90.12
17	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	36,412,700.00	35,062,723.00	1,349,977.00	96.29
18	Гэрэл цахилгаан	21,528,600.00	23,083,502.00	(1,554,902.00)	107.22
19	Түлш, халаалт	10,485,300.00	6,359,815.00	4,125,485.00	60.65
20	Цэвэр, бохир ус	4,398,800.00	5,619,406.00	(1,220,606.00)	127.75
22	Хангамж, бараа материалын зардал	59,495,400.00	52,937,397.00	6,558,003.00	88.98
23	Бичиг хэрэг	4,221,600.00	6,193,740.00	(1,972,140.00)	146.72
24	Тээвэр (шатахуун)	4,841,500.00	5,037,100.00	(195,600.00)	104.04
25	Шуудан холбоо	3,131,300.00	2,724,691.00	406,609.00	87.01
26	Ном хэвлэл авах	43,110,800.00	36,633,916.00	6,476,884.00	84.98
27	Хог хаягдал устгах цэвэрлэх	750,700.00	720,000.00	30,700.00	95.91
28	Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс	3,439,500.00	1,627,950.00	1,811,550.00	47.33
29	Нормативт зардал	941,000.00	195,000.00	746,000.00	20.72
32	Нормын хувцас зөөлөн эдлэл	941,000.00	195,000.00	746,000.00	20.72
33	Эд хогшил худалдан авах	6,731,500.00	4,147,300.00	2,584,200.00	61.61
36	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,022,000.00	1,383,300.00	638,700.00	68.41
37	Урсгал засвар	4,709,500.00	2,764,000.00	1,945,500.00	58.69
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	8,839,800.00	7,039,800.00	1,800,000.00	79.64
42	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,783,800.00	2,508,800.00	1,275,000.00	66.30
42	Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	-	1,000,000.00	(1,000,000.00)	-
43	Даатгалын үйлчилгээ	2,000,000.00	1,000,000.00	1,000,000.00	50.00
44	Тээврийн хэрэгслийн татвар	176,000.00	176,000.00	-	100.00
45	Тээврийн хэрэгслийн оношилгоо	255,000.00	255,000.00	-	100.00
47	Газрын төлбөр	2,625,000.00	2,100,000.00	525,000.00	80.00
50	Бараа үйлчилгээний бусад зардал	32,322,900.00	22,582,200.00	9,740,700.00	69.86
51	Бараа үйлчилгээний бусад зардал	17,383,600.00	17,383,600.00	-	100.00
52	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх				34.80

		14,939,300.00	5,198,600.00	9,740,700.00	
59	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,789,000.00	45,428,900.00	3,360,100.00	93.11
63	Бусад урсгал шилжүүлэг	48,789,000.00	45,428,900.00	3,360,100.00	93.11
66	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	43,748,900.00	43,748,900.00	-	100.00
71	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	5,040,100.00	1,680,000.00	3,360,100.00	33.33
87	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	519,434,700.00	562,372,586.00	(42,937,886.00)	108.27
92	Үндсан үйл ажиллагааны орлогоос санхүүжих	120,000,000.00	164,734,386.00	(164,734,386.00)	-
93	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-			-
96	Төсвөөс санхүүжих	399,434,700.00	397,638,200.00	1,796,500.00	99.55
104	Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	100.01	(100.01)	-
105	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	69,076,966.01	(69,076,966.01)	-
106	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
107	АЖИЛЛАГСАД БҮГД	33.00	33.00	-	100.00
108	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
109	Гүйцэтгэх ажилтан	10.00	10.00	-	100.00
110	Үйлчлэх ажилтан	22.00	22.00	-	100.00
111	СУРАЛЦАГСАД /жилийн дунджаар/	-	-	-	-
112	Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад	-	-	-	-

III. Авлага

2015 оны эхэнд авлагын бүртгэлд 47,627,305.13 төгрөг байсан бөгөөд тухайн тайлант хугацаанд 28,169,754.0 төгрөг болж буурсан байна. Энэ авлага нь дараа тооцоогоор үүсгэсэн ХЗҮХүрээлэнгийн гэрээт борлуулагч, гадны гэрээт борлуулагч нарт борлуулуулахаар өгсөн ном, сэтгүүлийн авлага юм.

IV. Өглөг

ХЗҮХ нь 844,479.0 төгрөгийн өглөгтэй байна

Бараа материалын хувьд оны эхнээс 29,731,395.0 төгрөгийн бараа материал орлого авч 27,697,315.0 төгрөгийн зарцуулалт хийгдсэн байна. 9 дугаар сарын байдлаар 131,645,119.15 төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байна.

V. Үндсэн хөрөнгө.

Монгол улсын Төрийн өмчийн хорооны 2015 оны 1 дүгээр сарын 28 ны өдрийн 11 дугаар тогтоолын дагуу үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 02-04 УБЗ улсын дугаартай 8,216,959.74 төгрөгийн өртөгтэй Тоёото Надиа суудлын автомашиныг Хууль зүйн туслалцааны төвд балансаас балансад зохих журмын дагуу автомашин хүлээлцэх акт үйлдэн шилжүүлсэн. Мөн 2015.07.02-ны өдрийн Төрийн өмчийн 446 дугаар тогтоолыг дагуу тус байгууллагын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 60,105,000 мянган төгрөгийн балансын үнэтэй, үлдэгдэл өртөггүй Тоёта Ландкрузер-105 маркийн суудлын шип автомашиныг ХХЕГ-т балансаас балансад шилжүүлж, тус газраас 35.684.591 төгрөгийн балансын үнэтэй 5.303.080 төгрөгийн үлдэх өртөгтэй 80-95 УБЕ улсын дугаартай Suzuki grand vitara суудлын автомашиныг балансаас балансад шилжиж ирсэнийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирлын 2015 оны 10-р сарын 01-ны өдрийн А-15 тоот тушаалаар байгуулагдсан тооллогын комисс Төрийн болон орон нутгийн өмчийн тухай

хууль, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эд хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтын тухай журмыг удирдлага болгон байгууллагын үндсэн хөрөнгийн тооллогыг явуулав.

2005-2008 онд ашиглалтанд орсон буюу байгууллагад хэрэглэгдээд 12 жил болж байгаа элэгдлийн норм, ашиглах хугацаа дууссан, засаж сэлбэхэд эдийн засгийн үр ашиггүй нь нотлогдсон дараахь 76 төрлийн 91 ширхэг 140,920,136 төгрөгийн техник тоног төхөөрөмж, 51 төрлийн 284 ширхэг 32,591,392 төгрөгийн тавилга эд хогшил, агуулгаар хуучирсан, элэгдэж гэмтэж уншигчдад үйлчлэх боломжгүй болсон 4,584,724.0 төгрөгийн номыг актлуулсан.

Мөн тус хүрээлэнгийн номын фондод илүүдэлтэй байгаа 131 төрлийн 3,062,204.0 төгрөгийн монгол номыг бусад хэрэгцээтэй номын сангуудад шилжүүлэх саналыг Хууль зүйн яам руу хүргүүлсэн.

Байгууллагын бараа материалын дансанд бүртгэлтэй 2003 онд ашиглалтанд орсон буюу байгууллагад хэрэглэгдэд 12 жил болж байгаа, зарим бага үнэтэй түргэн элэгдэх бараа материал нь ашиглах хугацаа дууссан буюу засаж сэлбэхэд эдийн засгийн үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон 17,033,944.0 төгрөгийн бараа материал, 25,142,245.0 төгрөгийн ном, сонин сэтгүүлийг дааснаас хасах саналтай байна.

Тооллогын явцад ноцтой зөрчил илрээгүй болно. Хүрээлэнгийн ажилтан тус бүр дээр эд хөрөнгө болон бараа материалын карт хөтөлж гарын үсэг зурж баталгаажуулсан. Мөн хөрөнгө тус бүрийн зургийг авч альбомжуулж, складанд дах ашигладаагүй эд хөрөнгө болон бараа материалыг хурааж эмхэлж цэгцлэж, эд хөрөнгө, бараа материалыг кодлох зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Жижиг мөнгөн санг 500,000.0 төгрөгт багтаан авсан. Тайланг тухай бүр гаргуулж, төсвийн гүйцэтгэлийн тайлан, нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан, Татварын тайланг улирал, сар бүр гаргаж цаг хугацаанд нь тайлагнаж байна.

Тус хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд байгууллагын санхүүгийн тайланг Шилэн дансны нэгдсэн портал сайт, болон маягтын дагуу байгууллагын цахим хуудаст байршуулж ажиллаж байна.

Аж ахуй, нярав, нийтлэг үйлчилгээ:

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн барилга, инженерийн шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, урсгал засвар, засвар үйлчилгээ, харуул үйлчилгээний ажилчдын өдөр тутмын ажлыг зохион байгуулж зааварчилгаа өгөх, ажлын журамтай танилцуулах, өдөр бүр рапорттай танилцах, илэрсэн зөрчлийг арилгуулан, гадна дотор цэвэрлэгээ, байгууллагын доторх эмх цэгц, эд аж ахуйн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагааг ханган, хүрээлэнгийн ажилтнуудын тав тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэн ажиллаж байна.

2015 онд хийж гүйцэтгэсэн ажлууд:

1. Бичиг хэргийн материалд: 2015.01.01-2015.12.31 хүртэл 18 нэр төрлийн 1.105.060.00 төгрөгний материал худалдан авч үүнээс нийт үлдэгдэл материалаас 2.075.847.00 төгрөгний бичиг хэргийн материал зарцуулсан.
2. Бэлэн бүтээгдэхүүн: Ном хэвлэл 14 нэр төрлийн 788ш 10.301.500.00 төгрөгний номыг худалдаанд гаргасан. Захиалагт сэтгүүл “Хууль зүйн мэдээлэл” 12 дугаар, нийт 7.216 ш 10.102.400 төгрөгний сэтгүүл шуудангаар тараасан.
3. Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн тооллогыг ажлын хуваарийн дагуу 2015.10.01-2015.11.01нд хийж гүйцэтгэсэн. Үүнд: Машин тоног төхөөрөмжийн бүртгэлд 2015 оны балансын

эхний бүртгэлтэй 1,212,490,626.87 төгрөгийн өртөгтэй нийт 187 нэр төрлийн 386 ширхэг тоног төхөөрөмж тоологдлоо. Үүнд 45 төрлийн 69 ширхэг нийт 120,214,601.77 төгрөгийн өртөгтэй телевизор болон бусад тоног төхөөрөмж, 18 төрлийн 118 ширхэг 129,193,864.70 төгрөгийн өртөгтэй компьютер болон дагалдах техник хэрэгсэл, 19 төрлийн 30 ширхэг 16,331,774.70 төгрөгийн нийт өртөгтэй хувилагч машин, 12 төрлийн 13 ширхэг 15,783,588.50 төгрөгийн нийт өртөгтэй сканнер болон сүлжээ салаалагч, 16 төрлийн 21 ширхэг 54,736,357.50 төгрөгийн нийт өртөгтэй хувилагч машин, 37 төрлийн 38 ширхэг 49,063,700.00 төгрөгийн нийт өртөгтэй төмрийн үйлдвэрийн тоног төхөөрөмж, 4 төрлийн 25 ширхэг 3,414,414.00 төгрөгийн нийт өртөгтэй тог баригч, 11 ширхэг 576,156,087.00 төгрөгийн нийт өртөгтэй хэвлэх үйлдвэрийн тоног төхөөрөмж, 56 ширхэг 226,063,648.60 төгрөгийн нийт өртөгтэй серверийн тоног төхөөрөмж, 11 ширхэг 21,532,590.00 төгрөгийн нийт өртөгтэй бусад тоног төхөөрөмж тоологдлоо.

Тавилга, эд хогшлийн бүртгэл 19,960,232.82 төгрөгийн 22 төрлийн 29 ширхэг буйдан, диван кресло, 70,110,094.24 төгрөг бүхий өртөгтэй 74 төрлийн 425 ширхэг албан тасалгааны, номын сангийн, сургалтын болон компьютерийн ширээ, 42,977,177.70 төгрөгийн өртөгтэй 32 төрлийн 474 ширхэг сандал, 13,087,119.50 төгрөгийн өртөгтэй 11 төрлийн 111 ширхэг файлын шүүгээ болон тумбочка, 86,597,309.22 төгрөгийн өртөгтэй 374 ширхэг номын шкаф, болон бусад тавилга эд хогшил, нийт 232,731,933.48 төгрөгийн өртөгтэй блансын бүртгэлтэй тавилга эд хогшил тоологдлоо.

Нийтийн эзэмшлийн байгууламжийн хөрөнгөд 2,475,000 төгрөгийн өртөгтэй 1 ширхэг төмөр хайс, хашаа, 625,000 төгрөгийн өртөгтэй 10 ширхэг нарс мод тоологдлоо. Эдгээр нийт эд хөрөнгийг ажилтан, албан хаагчдад картлаж засварлан гүйцэтгэж байна.

Бараа материалын бүртгэлд 62,498,487.44 төгрөгийн өртөгтэй 163 нэр төрлийн 1219 ширхэг бараа материал байна.

Бэлэн бүтээгдэхүүний бүртгэлд 67,976,806.22 төгрөгийг өртөгтэй 680 төрлийн 30251 ширхэг ном, сонин сэтгүүл байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Тооллогын комисс, Өмч хамгаалах байнгын зөвлөлөөр байгууллагын үндсэн хөрөнгийн тооллого хийсэн талаар хэлэлцэж, үүнээс дахин ашиглагдах боломжгүй болсон эд хөрөнгийг актлуулхаар тогтов.

Актлах эд хөрөнгийн жагсаалтыг нэг бүрчлэн нэгтгэн гаргаж, үндэслэлийг тодорхой болгов. Тооллогын комисс, Өмч хамгаалах зөвлөл өгөгдсөн үүргийн дагуу эвдэрч гэмтсэн эд хөрөнгийг засварлан сэлбэж, агуулахын эмх цэгц, эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг ханган ажиллаж байна.

4. Урсгал засварт ажлын төлөвлөгөөний дагуу цахилгааны 3 фазын тоолуур баталгаажуулж гадна талбайд камер 2ш дотор зааланд камер 2ш камерийг шинээр, 110ш өдрийн гэрэл 75ш гэрлийн өдөөгч, сантехникийн холигч 2ш сольж 3ш-г засварлаж тавьсан.

Байгуулага болон агуулах, дээврийн засвар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанаас 2015.05.18 зохион байгуулсан бүх нийтийн цэвэрлэгээнд гадна авто зогсоолын тэмдэглэгээ шинээр хийж, орж гарах хаалганы шонг будаж, байгууллагын гадна фасадны ховхорж унсан чулуун хавтанг нааж, дээврийн ус алдалтыг зогсоож, гадна цэцэрлэгжилтэнд 40ш хайлаас, 120ш шар хуайс мод суулган, халаалт, халуун усны тохиргоог тухай бүрт нь хийж, ус, дулаан, цахилгааны ямар нэгэн доголдолгүй ажиллалаа.

ШШГЕГазрын өр барагдуулах албанаас БЗД-ийн 4 хорооны нутаг дэвсгэрт байрлах аж ахуйн хашаа агуулахыг суллуулж хүлээн авлаа.

5. Жижиг мөнгөн сангийн зарцуулалт: 2015.03.01-2015.12.31 хүртэл нийт 8 удаа 4000000 төгрөг авсан.

	Үзүүлэлт	зарлага
1	Бичиг хэрэг.аж ахуй	382.540.0
2	Ном. Хэвлэл авах зардал	435.100.0
3	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	626.550.0
4	Урсгал засвар	896.880.0
5	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	979.960.0
6	Тээврийн хэрэгслийн оношилгоо	85.000.0
7	Шуудан холбоо интернет	184,720,0
8	Хичээл үйлдвэрлэлийн дадлага	49,900,0
9	Тээвэр шатхуун	276,000,0
10	Бараа үйлчилгээний бусад зардал	50,000,0
	Дүн	3.966.960.0 төг

Ажилтнуудын эзэмшиж байгаа эд хөрөнгө, бусад материалын бүртгэл картаар хөтлөгдөж, шилжилт хөдөлгөөн тухай бүрт хүлээлцэж байна.

Харуул, үйлчлэгч, мужаан нарт хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж ажилласан.

Товч дүгнэвэл: Захиргааны хэлтэс нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн 2015 оны үлй ажиллагааны төлөвлөгөө, дээд байгууллагын тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг зохиобиелэлтийн тайлан мэдээг Хууль зүйн яаманд тогтоосон хугацаанд хүргүүлж, хүний нөөцийн бүртгэл, хөдөлгөөн, материал бүрдүүлэлт, албан хаагчдын нийгмийн халамж дэмжлэг үзүүлэн, архив, албан хэрэг хөтлөлтийн хэвийн ажиллагааг хангаж, цалин хөлсийг хугацаанд нь олгож, байгууллагын санхүүгийн хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна.

Түүнчлэн байгууллагын барилга, инженерийн байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмжийн хэвийн найдвартай ажиллагааг хангах, засвар үйлчилгээ, цаг тухайд нь хийж, ашиглалтын явцад үүссэн гэмтлийг шуурхай засварлан, ус дулаан, цахилгааны ямар нэг доголдолгүй ажилласан.

Харуул, үйлчилгээний ажилчдын өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж байгууллагын эмх цэгц, аж ахуйн бүрэн бүтэн байдал, аюулгүй ажиллагаа, ажилтнуудын тав тухтай ажиллах нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч ажиллав.

Нийт төлөвлөгөөт ажлын биелэлт 100 хувьтай байна.

ТАЙЛАН ГАРГАСАН : ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРЭГ,
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖИЛТЭН

Б.ТУУЛ

ХЯНАСАН: ЗАХИРГААНЫ ХЭЛТСИЙН ЭРХЛЭГЧ

Д.БААТАРПҮРЭВ